



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГО,
ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: ГАА-2024/20-6-ШТА-ГА

Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор Г.Гүнжидмаа

Утас: 70483413

Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Аудитын менежер Д.Эрдэнэчимэг

Утас: 99175677

Цахим хаяг: Erdenechimegd@audit.gov.mn

Ахлах аудитор М.Атарцэцэг

Утас: 88984411

Цахим хаяг: Atartsetsegm@audit.gov.mn

Аудитор Э.Сүнжидмаа

Утас: 80048599

Цахим хаяг: Sunjidmaae@audit.gov.mn

Аудитор Н.Гэрэлмаа

Утас: 99782918

Цахим хаяг: Gerelmaan@audit.gov.mn

Тайлантай холбоотой мэдээллийг дээрх хаягаар холбогдож авна уу.
2024 он

АГУУЛГА

АУДИТЫН ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ:	5
АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ..	6
БҮЛЭГ 1. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ЧИГЛЭЛЭЭР ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС ХӨРӨНГӨ БАТЛААГҮЙ, НЭГДСЭН МЭДЭЭЛЛИЙН САН БҮРДЭЭГҮЙ БАЙНА.	9
1.1 Аймгийн хөгжлийн дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүдэд хүүхэд хамгаалах талаар хэрэгжүүлэх арга хэмжээг тусгасан ч орон нутгийн төсвөөс хөрөнгө зарцуулахаар батлаагүй байна.	9
1.2 Хүүхэд хамгааллын чиглэлээр мэргэшсэн албан хаагчид дутагдалтай, статистик мэдээгээр эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн тоо абле цахим систем дэх хүүхдийн тооноос зөрүүтэй, нэгдсэн мэдээллийн сан бүрдээгүй байна.	10
БҮЛЭГ 2. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ЗАРДЛЫН ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ ХАНГАЛТГҮЙ, АРГАЧЛАЛ, НОРМАТИВЫН ДАГУУ ТӨСВИЙГ ЗАРЦУУЛАХГҮЙ БАЙНА	13
2.1 Хүүхэд хамгааллын зардлын төсвийг бодит хүүхдийн тоон мэдээлэлд үндэслэн төлөвлөөгүй байна.	13
2.2 Шуурхай тусламж, хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний санхүүжилтийг зардлын аргачлал, нормативыг үндэслэн олгохгүй байна.	14
БҮЛЭГ 3. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯНАЛТ, САЛБАР ХООРОНДЫН УЯЛДАА ХОЛБОО ХАНГАЛТГҮЙ БАЙНА.	16
3.1 Хүүхэд хамгааллын талаар хэрэгжиж буй үйл ажиллагаанд тавих хяналт хангалтгүй байна.	16
3.2 Хүүхэд хамгааллын оролцогч талуудын хэрэгжүүлж буй арга хэмжээгээр нийгэмд эерэг нөлөөлөл бий болж байгаа хэдий ч гэр бүлийн орчин дахь зөрчил буурахгүй байна.	18
3.3 Хамтарсан багийн гишүүдийн ажлын чиг үүргийн хэрэгжилт хангалтгүйгээс эрсдэлт нөхцөлд орсон хүүхдэд үзүүлэх хариу арга хэмжээг бүрэн үзүүлдэггүй, салбар хоорондын уялдаа холбоо хангалтгүй байна.	22
ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ: ЭРСДЭЛТ НӨХЦӨЛД БАЙГАА ХҮҮХДИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САНГ БҮРДҮҮЛЭЭГҮЙ, ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙГЭЭС ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН БОДЛОГЫГ ОНОВЧТОЙ ТОДОРХОЙЛОХ, ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭГ БҮРЭН ҮЗҮҮЛЭХ НӨХЦӨЛ БҮРДЭХГҮЙ БАЙНА.	27
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:	29

Товчилсон үгийн тайлбар

АДБОУБ	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын байгууллага
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ГА	Гүйцэтгэлийн аудит
ГАА	Говь-Алтай аймаг
ГБХЗХЕГ	Гэр бүл, хүүхэд, залуучууд хөгжлийн ерөнхий газар
ГХУСАЗСЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
НҮБ	Нэгдсэн Үндэсний Байгууллага
ХГБХХГ	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар
ХНХС	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
ХЭХЗХ	Хүүхдийн Эрхийн хууль зүйн хороо
ОУБ	Олон Улсын байгууллага



№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт №1	ХЭХЗХ-нд бүртгэлтэй хүүхдийн судалгаа	11
Хүснэгт №2	ХГБХХГ-ын хүний нөөцийн мэдээлэл	12
Хүснэгт №3	Хүүхэд хамгааллын зардлын төсвийн гүйцэтгэл	14
Хүснэгт №4	ОУБ-аас хүүхэд хамгаалалд зарцуулалт	15
Хүснэгт №5	Урьдчилан сэргийлэх үйлчилгээний зардлыг нормативын дагуу тооцоолсон байдал	16
Хүснэгт №6	Бодлогын хэрэгжилт 2019-2023 дунджаар	18
Хүснэгт №7	Эрүүл мэндийн салбарын хамтарсан багийн тоон судалгаа	20
Хүснэгт №8	Хүснэгт 8. Хурдан морь унаач хүүхдийн судалгаа	21
Хүснэгт №9	Хүүхдийн тусламжийн 108 утасны дуудлага	22
Хүснэгт №10	Хүүхдийн үйлдсэн гэмт хэргийн судалгаа	25
Хүснэгт №11	Гэмт хэргийн улмаас хохирсон хүүхдийн судалгаа	25
Хүснэгт №12	Боловсролын салбарт гардаг хүүхдийн хүчирхийллийн судалгаа	28
Хүснэгт №13	Осол, гэмтлийн улмаас нас барсан хүүхдийн судалгаа	28
Хүснэгт №14	Хүүхдийн осол, гэмтлийн улмаас өвдөж, гэмтсэн судалгаа	28

Дүрслэлийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл №1	Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал	13
Дүрслэл №2	Хүүхэд хамгааллын зардлын ил байдал	14
Дүрслэл №3	Хүүхдийн тусламжийн 108 утасны дуудлага төрлөөр	23
Дүрслэл №4	Түр хамгаалах байраар үйлчлүүлсэн иргэдийн тоо	24
Дүрслэл №5	Үр хөндөлтийн судалгаа	26

Зургийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг №1	Мэргэжлийн боловсролын сургуулийн дотуур байрны орчин нөхцөл	19
Зураг №2	Аймгийн Түр хамгаалах байр	25

Хавсралтын товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт №1	Ерөнхий боловсролын сургуулийн камержуулалт	19
Хавсралт №2	Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны стандарт	19

АУДИТЫН ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ:



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2024 оны 10 сарын 25 өдөр

Дугаар А/26

Есөнбулаг

Гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/102 дугаар "Эрх шилжүүлэх тухай" тушаалын дөрөвдүгээр хавсралтын 1 дүгээр зүйлийн 1.1, 1.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр, аудитаар өгсөн албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Үндэсний аудитын газар, Аймгийн Засаг дарга, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, Боловсрол, шинжлэх ухааны газар, Мэргэжлийн боловсролын сургууль, Хүүхдийн эрхийн хууль зүйн хороонд тус тус хүргүүлсүгэй.

3. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмж, шийдвэрийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасан хугацаанд, биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Аймгийн Засаг дарга, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, Боловсрол, шинжлэх ухааны газар, Мэргэжлийн боловсролын сургууль, Хүүхдийн эрхийн хууль зүйн хороод тус тус зөвлөсүгэй.

4. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон байгууллагын архивд хүлээлгэн өгөхийг аудитын баг (М.Атарцэцэг)-т үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Д.Эрдэнэчимэг)-т даалгасугай.


Г.ГҮНЖИДМАА

07019088

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны “Аудитын сэдэв батлах тухай” 08 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” 2024 оны А/162 дугаар тушаалыг тус тус үндэслэн аудитыг хийж гүйцэтгэлээ.

Аудитын зорилт

“Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн”-д гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдлээ. Аудитын зорилгыг хангахын тулд аудитыг дараах дэд зорилтын хүрэнд гүйцэтгэсэн. Үүнд:

- Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, төлөвлөлтийн тогтолцоо оновчтой эсэх;
- Хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөлт, төсөвлөлт үр өгөөжтэй, хүүхдэд ээлтэй байж чадсан эсэх;
- Хүүхэд хамгааллын талаар баримталж буй бодлогын хэрэгжилт үр дүнтэй эсэх.

Аудитын хамарсан хүрээ

Аудитад Хүүхэд хамгааллын тухай хуулийн хүрээнд хүүхэд хамгааллын чиглэлээр, үйл ажиллагаанд оролцдог ХГБХХГ, ГХУСАЗСЗ, ХЭХЗХ, Хүүхдийн төлөө зөвлөл, Эрүүл мэндийн газар, Цагдаагийн газар, Соёл урлагийн газар, Боловсрол шинжлэх ухааны газар, Биеийн тамир спортын газар, Ерөнхий боловсролын сургууль, Сургуулийн өмнөх боловсрол зэрэг байгууллагуудын 2019-2023 онуудын мэдээлэл, судалгаа, тайлан, баримт материалыг хамруулан шалгалаа.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУБ (INTOSAI)-ын стандартын хорооноос баталсан АДБОУС 100, АДБОУС-300, АДБОУС-3000-3200-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 Төрийн аудит.Тулгуур зарчим, MNS6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит.Нийцлийн аудит”-ын стандартад заасан , арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, түүнд нэмэлт өөрчлөлт оруулсан Монгол Улсын Ерөнхий аудиторов 2021 оны А/69 дугаар тушаалаар батлагдсан “Гүйцэтгэлийн аудитын заавар аргачлал”-ыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт зөвлөмж боловсрууллаа.

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Г.Гүнжидмаа хянан удирдаж, аудитын менежер Д.Эрдэнэчимэг аудитын үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор М.Атарцэцэг, аудитор Э.Сүнжидмаа, Н.Гэрэлмаа нар баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Аудитын гүйцэтгэх үе шатны талбарын ажлыг 2024 оны 08 дугаар сарын 26-ны өдрөөс 2024 оны 10 дугаар сарын 14-ний өдөр хүртэл гүйцэтгэж, нэгтгэлийг 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөс 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдөр хийж аудитын тайланг 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдөр баталгаажуулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэв.

**Аудитад ашигласан
хууль тогтоомж,
шалгуур үзүүлэлт**

Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

Үүнд: Хүүхдийн Эрхийн Тухай Конвенц, Монгол Улсын Үндсэн хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Боловсролын тухай хууль, Төсвийн тухай хууль, Шилэн дансны тухай хуулиуд болон Засгийн газрын 2002 оны 245 дугаар тогтоолоор баталсан Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоолоор баталсан Хүүхэд хамгааллын чиглэлээр баримтлах бодлого, чиглэл, Аймгийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл зэргийг шалгуур болгон авч үзлээ.

Хүндрэл бэрхшээл

ХГБХХГ-ын 2019-2023 онуудын баримт материал эмх цэгцгүй, бүрэн архивын нэгж үүсгээгүй, мэдээллийн нэгдсэн сан бүрдээгүй зэргээс мэдээлэл авах явц удаашралтай, хүндрэлтэй байлаа.

Аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлтэй уулзалт хийхээр төлөвлөсөн боловч орон нутгийн сонгууль давхацсантай холбоотойгоор хийгдээгүй болно.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Хүүхэд хамгааллын тухай хууль анх 2016 онд батлагдсанаас хойш 6 удаагийн нэмэлт өөрчлөлт орж, 50 орчим журам, 8 стандартыг мөрдөж ажиллаж байна. Мөн Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2023 онд батлагдсан бөгөөд 2024 оны 9 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж байна.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгад “хүүхэд хамгаалал” гэж нийгмийн бүх орчинд хүүхэдтэй зүй бус харьцах, хүүхдийг хүчирхийлэл, мөлжлөгт өртөхөөс хамгаалах, нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн энэ хуульд заасан зарчмыг баримталсан цогц бодлого, үйл ажиллагаа, үйлчилгээг хэлнэ гэж заасан. Харин “хүүхэд хамгааллын үйлчилгээ” гэж хүүхэд хамгааллын тогтолцооны оролцогч талуудаас хүүхдийн хамгаалуулах эрхийг хангах зорилгоор үзүүлж байгаа шуурхай тусламжийн, хамгаалах, нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэх хэлбэрээр үзүүлж байгаа үйлчилгээг хэлнэ” гэж тус заасан байна.

Хүүхэд хамгааллын талаар НҮБ-ын хүүхдийн эрхийн конвенц, Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичиг “Алсын хараа-2050”, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоолоор баталсан Хүүхэд хамгааллын чиглэлээр баримтлах бодлого, чиглэл, Засгийн газрын 2002

оны 245 дугаар тогтоолоор баталсан “Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр”-т тус тус тусган хэрэгжүүлж байна.

Аймгийн хэмжээнд “Аймгийн эдийн засаг, нийгмийг 2019-2023 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”, Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т хүүхэд хамгааллын чиглэлээр 19 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгажээ.

Говь-Алтай аймаг 18 сум, 2 тосгонтой, 2023 оны байдлаар нийт хүн ам 57328, үүнээс 0-18 насны хүүхэд 20332 байна. Үүнээс эрсдэлт нөхцөл дэх хүүхдийн тоо 2126 буюу нийт хүүхдийн 10.4 хувийг эзэлж байна. /Эх сурвалж: ХГБХХГ-ын судалгаа -2023/

Аймгийн хэмжээнд хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвд 2023 онд нийт 76 дуудлага ирсний 42 нь зорилтод дуудлага, үүнийг өмнөх онтой харьцуулахад нийт дуудлага 12.0 хувиар, зорилтод дуудлага 15.0 хувиар өсжээ. Хүүхэд хамгааллын үйлчилгээнд 2023 онд 1002 хүүхэд хамрагдсан нь 2022 онтой харьцуулахад 32.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Говь-Алтай аймгийн хэмжээнд хүүхэд хамгааллын чиглэлээр ХГБХХГ, Эрүүл мэндийн газар, Цагдаагийн газар, Соёл урлагийн газар, Боловсрол, шинжлэх ухааны газар, Биеийн тамир спортын газар, Ерөнхий боловсролын 24 сургууль, 30 цэцэрлэг, нийт 60 төрийн байгууллага, ГХУСАЗСЗ, ХЭХЗХ, Хүүхдийн төлөө зөвлөл, 18 сум, 2 тосгонд 30 хамтарсан баг үйл ажиллагаа явуулж байна.

Хүүхэд хамгааллын үйлчилгээ эрхлэх магадлан итгэмжлэгдсэн 1 байгууллага, хүүхэд асрах үйлчилгээ эрхэлдэг 3 төв байна.

Аймгийн Нэгдсэн эмнэлэгт 2014-2022 онд “Нэг цэгийн үйлчилгээний төв” байгуулан хүчирхийлэлд өртсөн иргэд, хүүхдийг түр хамгаалах үйлчилгээг үзүүлсэн бөгөөд 2023 оноос ГХУСАЗСЗ-ийн тогтоолоор Монголын Улаан загалмай нийгэмлэг үндэсний хүмүүнлэгийн байгууллагын Говь-Алтай аймаг дахь салбараар гүйцэтгүүлэхээр шийдвэрлэсэн байна. Түр хамгаалах байранд 2023 онд 15 хүүхэд үйлчилгээ авсан байна.

Говь-Алтай аймагт улсын төсвөөс хүүхэд хамгааллын зардалд 2019 онд 67.5 сая төгрөг, 2023 онд 109.3 сая төгрөгийг баталсан нь 38.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

БҮЛЭГ 1. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ЧИГЛЭЛЭЭР ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС ХӨРӨНГӨ БАТЛААГҮЙ, НЭГДСЭН МЭДЭЭЛЛИЙН САН БҮРДЭЭГҮЙ БАЙНА.

1.1 Аймгийн хөгжлийн дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүдэд хүүхэд хамгаалах талаар хэрэгжүүлэх арга хэмжээг тусгасан ч орон нутгийн төсвөөс хөрөнгө зарцуулахаар батлаагүй байна.

1.1.1 Аймгийн дунд болон богино хугацааны бодлого нь хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүдтэй уялдаж байгаа хэдий ч хүүхэд хамгааллын үр дүнтэй тогтолцоог бэхжүүлэх, хамгааллын үйлчилгээг тогтвортой чанартай хүргэх, хуулиар хүлээсэн чиг үүргийг бүрэн хэрэгжүүлэх, салбар хоорондын үр дүнтэй зохицуулалтыг хангахгүй байна.

1.1.2 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”, “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр”-тэй уялдуулан боловсруулсан “Аймгийн эдийн засаг, нийгмийг 2019, 2020, 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”, “Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд хүүхэд хамгааллын талаар дараах ажлуудыг тусгасан байна. Тухайлбал:

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг эрүүл мэндийн үзлэгт хамруулж, эмчилнэ;
 - Нэгдсэн эмнэлэгт гэмтэл, яаралтай тусламжийн тасгийг бие даалган байгуулж, эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын өрөө, шинэ төрөх эмнэлэгт мэс заслын блок, хүүхдийн тасагт нярайн өрөө, сэтгэцийн тасагт хүүхдийн өрөө байгуулна;
 - Сургууль, цэцэрлэг, дотуур байранд хүүхдэд ээлтэй, эрүүл аюулгүй орчин бүрдүүлнэ;
 - Сумдын цэцэрлэг, сургууль, дотуур байрны цэвэр усан хангамж, ариун цэврийн байгууламжийг орчин үеийн стандартад нийцүүлэн үе шаттайгаар шийдвэрлэнэ;
 - Сургууль, цэцэрлэгийн орчныг гэрэлтүүлэг, налуу зам, гарц, гэрлэн дохио, камер, хурд сааруулагчтай болгож хүүхдийг эрсдэлээс хамгаална;
 - Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн түүний асран хамгаалагчдыг нөхөн сэргээх эмчилгээний арга барилд сургах, сургалт сурталчилгааг өргөжүүлнэ;
 - “Эрүүл шүд-Эрүүл хүүхэд” хөтөлбөрийн хүрээнд 5, 6, 12 насны хүүхдийг шүдний өвчлөлөөс урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулна;
 - Аймгийн хэмжээний сургууль, цэцэрлэгийг камержуулж, хүүхдэд ээлтэй, аюулгүй орчин бүрдүүлнэ;
 - Алтай хотын телекамерын тоог нэмэгдүүлэн, засвар үйлчилгээг хийж, хяналтын системийг сайжруулна;
 - Хүчирхийлэлд өртсөн иргэдэд нэг цэгийн үйлчилгээний төвийг хэвийн үйл ажиллагаатай болгож, эрсдэлт нөхцөлд байгаа гэр бүлийг хамгаалж, хамтарсан багаар үйлчилгээ үзүүлнэ;
- Хүүхэд, эмэгтэйчүүдийг хамгаалах байрыг ашиглалтад оруулж, үйл ажиллагааг жигдрүүлнэ.

1.1.3 Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 2019-2023 онуудад зөвхөн хүүхдийн хөгжил, оролцоог хангах тэднээс ирүүлсэн хүсэлтийг шийдвэрлэх зорилгоор 122.9 сая төгрөгийг зарцуулсан байна.

1.1.4 Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 2018-2024 онд хүүхдэд чиглэсэн “Хүүхдэд ээлтэй Алтай”, “Засагт ханы хүүхдүүд” дэд хөтөлбөр, арга хэмжээг батлан хэрэгжүүлсэн боловч уг хөтөлбөрт эрсдэлт нөхцөл дэх хүүхдийг хамгаалахад чиглэсэн арга хэмжээ тусгаагүй. Тухайлбал аймгийн хэмжээнд 2023 оны байдлаар эрсдэлт нөхцөл дэх хүүхэд 2126, үүнээс хөгжлийн бэрхшээлтэй 315, хурдан морь унаач 633, гэмт хэрэгт холбогдсон 20, гэмт хэргийн хохирогч болсон 13 хүүхэд байна.

1.1.5 Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 31 дүгээр тогтоолоор “Хүүхдэд ээлтэй-Алтай” дэд хөтөлбөрийг баталж хүүхдэд ээлтэй аймаг болох зорилгыг дэвшүүлэн 5 жилийн хугацаанд НҮБ-ын Хүүхдийн сангаас 2,610.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авч орон нутгийн ард иргэд, хүүхдэд чиглэсэн хөрөнгө оруулалт нэмэгдэн бодит үр дүнгээ өгсөн байна. Тухайлбал хөтөлбөрт хүүхэд хамгаалалтай холбоотой дараах ажлуудыг тусгасан байна.

- Сургууль, цэцэрлэгийг стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангана;
- Сургууль цэцэрлэг, айл өрхийг хүнсний эрүүл ахуйн шаардлага хангасан ундны усны саваар хангана;

- Дотуур байрны орчин нөхцөлийг гэрийн нөхцөлд ойртуулна;
- Сургууль цэцэрлэгийн орчинд замын тэмдэг тэмдэглэгээг сайжруулж, хурд сааруулагчийг хийж зам тээврийн осолд өртөхөөс сэргийлнэ;
- Гэр хорооллын гудамжийг гэрэлтүүлэгтэй болгох, золбин нохойг устгах, явган хүний замыг сайжруулах, хог хаягдлыг багасгах, архи тамхи худалдаалдаг дэлгүүр цэгийг цөөлөх
- Сургууль цэцэрлэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хамрагдах дэд бүтцийг нэмэгдүүлнэ;
- Хурдан морь унаач хүүхдийн аюулгүй байдлыг ханган 100.0 хувь хамгаалалтын хувцас хэрэгсэлтэйгээр уралдааны замд гаргаж хэвшүүлнэ;
- Хүйтний улиралд гэр хорооллын хүүхдүүдийг тээвэрлэх, зуны улиралд зусланд амрах хүүхдүүдийг тээвэрлэх зориулалт бүхий хүүхдийн автобустай болно;
- Бага насны хүүхдийг осол гэмтлээс хамгаалах зорилгоор "Суурьтай халуун тогоо" аяныг өрнүүлж зорилтот өрхийн айлуудыг халуун тогооны сууриар хангана;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сэргээн засах, нийгэмшүүлэх, хөгжүүлэхэд сургалтын төвүүдийг байгуулан ажиллуулах;
- Бүтэн өнчин хүүхдүүдэд хадгаламжийн хуримтлал бий болгох;
- Сургуулиуд дээр сэтгэл заслын өрөө байгуулах;
- Цагдаагийн газарт хүүхэд байцаалт өгөх орчныг бүрдүүлэн тусгайлсан өрөөг бий болгоно;
- Цагдаагийн кабоныг түшиглэн түр хамгаалах байрыг сумдад тохижуулна.

1.1.6 Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 51 дүгээр тогтоолоор хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, сурч боловсрох, хөгжих, хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох эрхийг хангах, хүүхэд хамгааллын тогтолцоог бусад салбарын оролцоотойгоор бэхжүүлэх, хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлэх зорилготой “Засагт ханы хүүхдүүд” арга хэмжээг баталжээ. Үүнд:

- Хүүхдүүдийг эрт илрүүлэх, төвийн үйлчилгээнд хамруулж, эцэг эхчүүдэд хүүхдээ асрах, хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээд хамруулах талаар сургалт зохион байгуулна;
- Аливаа үйл ажиллагаанд оролцох боломжгүй хүүхдүүдэд "Гэр үйлчилгээ"-г үзүүлэх;
- Уралдаанч хүүхдийг хурууны хээгээр бүргэж, эрсдэлийн түвшин тогтоох программд оруулах

1.1.7 Хүүхэд хамгааллын чиглэлээр аймгийн дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тодорхой асуудлуудыг тусган, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байгаа хэдий ч хүүхэд хамгааллын чиглэлээр орон нутгийн төсвөөс хөрөнгө батлаагүй байна.

1.2 Хүүхэд хамгааллын чиглэлээр мэргэшсэн албан хаагчид дутагдалтай, статистик мэдээгээр эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн тоо абле цахим систем дэх хүүхдийн тооноос зөрүүтэй, нэгдсэн мэдээллийн сан бүрдээгүй байна.

1.2.1 ХГБХХГ нь Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18 дугаар зүйл, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

1.2.2 Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.2¹-т заасан чиг үүргийн хүрээнд IDLO Олон улсын эрх зүйн байгууллагатай хамтран ХЭХЗХ-ны 12 гишүүнийг жилд 1-2 удаагийн чадавхжуулах сургалтад хамруулсан. Мөн гишүүдийг сайн туршлага судлах зорилгоор Баянхонгор аймгийн иргэдэд сэтгэц, нийгмийн сэргээн засах тусалцаа үзүүлэх “Жаргалтай амьдрал төв”, Түр хамгаалах байрны үйл ажиллагаатай танилцуулсан зэрэг үр дүнтэй ажлуудыг зохион байгуулсан байна.

1.2.3 ХЭХЗХ нь хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хүүхдүүдэд 5 чиглэлээр 76 удаагийн сургалт нөлөөллийн ажлыг давхардсан тоогоор 373 хүүхдэд зохион байгуулсан. Сүүлийн жилүүдэд гэмт хэрэгт холбогдсон болон гэмт хэргийн хохирогч, зөрчил үйлдэж шийтгүүлсэн хүүхдүүдийн тоо 2020-2023 онуудад 19.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Аймгийн хэмжээнд гэр бүлээсээ дайжсан, эцэг, эх, асран хамгаалагчийн халамж анхаарал, хараа хяналтаас гадуур байгаа хүүхдийг бүртгээгүй байна.

¹ 18.2.2.төрийн байгууллага, хуулийн этгээд, шүүх, прокурор, хууль сахиулах байгууллагын хүүхдийн асуудал хариуцсан ажилтан, алба хаагчдыг сургах, мэргэшүүлэх,

Хүснэгт 1. ХЭХЗХ-нд бүртгэлтэй хүүхдийн судалгаа

Он	Зөрчил үйлдэж шийтгүүлсэн хүүхдийн тоо	Гэмт хэрэг үйлдэж шүүхээр шийтгүүлсэн хүүхдийн тоо	Гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн тоо	Гэмт хэргийн хохирогч	Нийт хүүхдийн тоо
2019	7	7	14	20	48
2020	15	4	6	10	35
2021	23	5	9	21	58
2022	37	6	7	19	69
2023	31	7	18	12	68

Эх сурвалж: ХГБХХГ-аас ирүүлсэн судалгаа

1.2.4 ХЭХЗХ нь үйл ажиллагааны тайланг 2023 онд аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлд хэлэлцүүлсэн бөгөөд өмнөх онуудад тайлагнаагүй, хүүхэдтэй холбоотой мэдээлэл, хэрэгжүүлсэн арга хэмжээ тодорхойгүйгээс дүн шинжилгээ хийх нөхцөл бүрдээгүй байна.

1.2.5 ХГБХХГ нь сургалт нөлөөллийн ажлыг хуульд заасан зорилтот бүлгүүдэд зохион байгуулж хэвшжээ. Үүнд: Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.4²-т заасан сургалтыг 17 чиглэлээр давхардсан тоогоор 2235 хүнд, 18.2.6³, 18.2.7⁴-д заасны дагуу 37 чиглэлээр давхардсан тоогоор 6931 иргэнд тус тус сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулсан байна.

1.2.6 Аймгийн ХГБХХГ-т хүүхдийн эрхийн улсын байцаагч нь хүүхдийн эрх, хамгаалалтай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтэд 2019-2023 онуудад дараах чиглэлээр хяналт шалгалт хийж холбогдох албан тушаалтанд 4 албан шаардлага, 11 зөвлөмж өгч хэрэгжилтийг хангуулан ажилласан байна. Үүнд:

- Жил бүр Засгийн газрын 57 дугаар тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллах зөвлөмжийг хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж 5 зөвлөмжийг холбогдох албан тушаалтанд хүргүүлж биелэлтийг хангуулсан;
- Байгууллага аж ахуйн нэгжийн дэргэдэх "Эцэг эхийн зөвлөл"-ийн үйл ажиллагааг сайжруулах зөвлөмжийг 4 удаа байгууллагуудад хүргүүлэн ажилласан байна. Үүний үр дүнд байгууллага аж ахуйн дэргэдэх зөвлөлийн үйл ажиллагаа сайжирч "Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлж, ажилтан албан хаагчдын гэр бүлд чиглэсэн үйл ажиллагааг тогтмол зохион байгуулсан;
- Сумын нийгмийн бодлогын мэргэжилтний ажлыг сайжруулах чиглэлээр 3 удаагийн албан шаардлагыг холбогдох албан тушаалтанд хүргүүлж хэрэгжилтийг хангуулан ажилласан;
- Дотуур байранд амьдарч байгаа хүүхдүүдийн эрхийг хамгаалах албан шаардлага хүргүүлж, хэрэгжилтийг хангуулсан;
- Хүүхэд харах үйлчилгээний Нархан, Итгэл, Жаргалын төвд зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлсэн, Зөрчлийн тухай хуулиар хариуцлага тооцож ажилласан байна.

1.2.7 Хүүхдийн эрхийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.6⁵; Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.8⁶-д тус тус заасны дагуу хүүхдийн эрх, хамгааллын талаар нэгдсэн статистик мэдээллийн сан бүрдүүлэн үйл ажиллагаандаа ашиглах зохицуулалтай ч, хүүхэд хамгааллын мэдээллийн нэгдсэн сан бүрдээгүйгээс аймгийн хэмжээний урьдчилан сэргийлэх, хамгаалах, нөхөн сэргээх, тусламж үйлчилгээний дэлгэрэнгүй суурь мэдээлэлгүй байна. Статистик мэдээгээр эрсдэлт нөхцөл дэх

² 18.2.4.нийгмийн ажилтан, хамтарсан баг, хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэгчийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

³ 18.2.6.эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хүүхэд харагчийг сайн дурын болон хуульд заасны дагуу шүүхийн шийдвэрээр албадан сургалтад хамруулах ажлыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагатай хамтран зохион байгуулах;

⁴ 18.2.7.гэр бүлээсээ дайжсан, эсхүл эцэг, эх, асран хамгаалагчийн халамж анхаарал, хараа хяналтаас гадуур байгаа хүүхдийг бүртгэх, судалгаанд авах, гэр бүлд нэгтгэх ажлыг орон нутгийн Цагдаагийн байгууллагатай хамтран гүйцэтгэх.

⁵ 14.1.6.хүүхдийн эрхийн талаар мэдээллийн сан бүрдүүлж, ашиглах;

⁶ 18.1.8.хууль сахиулах байгууллагатай хамтран хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчил үйлдсэн иргэн, хуулийн этгээд, хууль зөрчигч хүүхэд, гэрч, хохирогч хүүхдийн талаар мэдээллийн сан бүрдүүлж үйл ажиллагаандаа ашиглах;

хүүхдийн тоо 2023 оны байдлаар 2126 байхад абле цахим системд 635 хүүхэд бүртгэлтэй байна.

- 1.2.8 Абле цахим системд 2019-2022 оны мэдээллийн сан бүрэн үүсээгүй, хүүхэд хамгааллын үйлчилгээг оруулах цэс идэвхгүй, нэгтгэл мэдээллээр эрсдэлийн түвшин гардаггүй, мөн 2020 оноос нэвтрүүлсэн НАМС цахим систем хөгжүүлэлт хийгээгүйгээс одоо ашиглахгүй байна.
- 1.2.9 Мэдээллийн нэгдсэн сангүйгээс хүүхэд хамгааллын үйлчилгээг оновчтой төлөвлөх, үйлчилгээний үр дүнг үнэлж дүн шинжилгээ хийх боломжгүй зэргээс шалтгаалан бодлого төлөвлөлт бодитой хийгдэхгүй байна.
- 1.2.10 Салбарын хэмжээнд хүүхэд хамгааллын тогтолцоог бүхэлд нь хамарсан мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, цахим системийн хөгжүүлэлт, ашиглалтыг сайжруулах шаардлагатай байна.
- 1.2.11 ХГБХХГ-ын бүтэц орон тоог 2016-2019 онд аймгийн Засаг даргын захирамжаар 26, 2020-2021 онд 29, 2022-2023 онд Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын тушаалаар 24 орон тоотойгоор баталсан байна.

Хүснэгт 2. ХГБХХГ-ын хүний нөөцийн мэдээлэл

Он	Хүний нөөцийн мэдээлэл				
	Батлагдсан орон тоо	Ажиллаж байгаа орон тоо	Үүнээс: Нийгмийн ажилтан	Сэтгэл зүйч	Бусад
2019	26	26	-	-	26
2020	29	28	1	-	27
2021	29	26	1	-	25
2022	24	24	-	-	24
2023	24	24	-	-	24

Эх сурвалж нь: ХГБХХГ-аас ирүүлсэн судалгаа

- 1.2.12 Хүүхдэд хамгааллын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1⁷д сум, орон нутагт нийгмийн ажилтан ажиллуулах заалттай ч нийгмийн ажилтны үндсэн орон тоогүй, сумын нийгмийн бодлого хариуцсан мэргэжилтэн уг ажлыг гүйцэтгэж байна.
- 1.2.13 Аймгийн хэмжээнд хүүхэд хамгааллын үйлчилгээг хүргэх чиг үүрэг бүхий ХГБХХГ-т улсын байцаагч 1, ахлах мэргэжилтэн 1, хөгжил, оролцоо хариуцсан мэргэжилтэн тус бүр 1, цагдаагийн байгууллагад хүүхдийн асуудал хариуцсан ахлах 1, Боловсрол шинжлэх ухааны газарт хүүхэд хамгаалал хариуцсан ахлах мэргэжилтэн 1, сургуулийн нийгмийн ажилтан 28, сэтгэл зүйч 12, сумдын нийгмийн бодлого хариуцсан мэргэжилтэн болон багийн нийгмийн ажилтан 28 ажиллаж байна.
- 1.2.14 Хүүхэд хамгааллын салбарт ажиллаж буй 74 албан хаагчийн 62.0 хувь нь 1-3 жил ажиллаж байгаа, Есөнбулаг сумын 7 баг, Төгрөг, Тайшир сумын нийгмийн ажилтан мэргэжлийн бус албан хаагч байна. Хөдөө орон нутагт мэргэжлийн боловсон хүчин, тогтвор суурьшилгүй, Есөнбулаг сумын тухайд багийн нийгмийн ажилтнуудыг баг хооронд сэлгэн ажиллуулж байгаа зэрэг нь ажлын үр дүн, бүтээмжийг бууруулж байна.


⁷ 20.1.Орон нутгийн хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан байгууллага нь нутгийн өөрөө удирдах байгууллагатай зөвшилцөн сум, баг, дүүрэг, хороонд хүүхдийн асуудал хариуцсан нийгмийн ажилтан ажиллуулна.

БҮЛЭГ 2. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ЗАРДЛЫН ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ ХАНГАЛТГҮЙ, АРГАЧЛАЛ, НОРМАТИВЫН ДАГУУ ТӨСВИЙГ ЗАРЦУУЛАХГҮЙ БАЙНА.

2.1 Хүүхэд хамгааллын зардлын төсвийг бодит хүүхдийн тоон мэдээлэлд үндэслэн төлөвлөөгүй байна.

- 2.1.1 Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй. ХГБХХГ нь 2019-2022 онуудын хүүхэд хамгааллын төсвийн төлөвлөлт хийсэн тооцоолол, судалгааны нотлох баримтгүй, шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг оруулаагүй байна.
- 2.1.2 Хүүхэд хамгааллын зардлын 2023 оны төсвийн төслийг боловсруулахдаа бодит хүүхдийн тоон мэдээлэлд үндэслэдэггүй, мөн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын А/23, А/27 дугаар тушаалаар “Хүүхдийн хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив”-аар зардлыг тооцоогүй байна. Боловсруулсан төсвийн төслийн дүнгээс 4 дахин бууруулж баталсан нь төлөвлөлтийг оновчтой хийгээгүйг харуулж байна.
- 2.1.3 Хүүхэд хамгааллын урьдчилан сэргээх зардалд нийт 194.4 сая төгрөгийг зарцуулсны 113.2 сая төгрөгийг урьдчилан сэргийлэх арга хэмжээнд, 81.2 сая төгрөгийг хүүхдийн хөгжил оролцоог дэмжих чиглэлд тус тус зарцуулжээ.
- 2.1.4 Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын 1.0 хувийг “Итгэлтэй утас”-ны төлбөрт, 2.0 хувийг олон нийтийн цахим хэрэгслээр урьдчилан сэргийлэх мэдээлэл дамжуулсны хөлсөнд, 11.1 хувийг эрсдэлт нөхцөл дэх хүүхдийг хүүхэд хамгааллын даатгалд хамруулсны төлбөрт, 15.8 хувийг 2020-2022 онуудад ковидын үед урьдчилан сэргийлэх арга хэмжээнд, 74.0 хувийг сургалт, нөлөөллийн ажилд тус тус зарцуулсан нь урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, хүүхдийн эрхийн зөрчлийн шалтгаан нөхцөлийг бууруулахад чиглэсэн байна.

Дүрслэл 1. Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал сая төгрөгөөр



Эх сурвалж: Ажлын баримт

- 2.1.5 Хүүхэд хамгааллын тухай хуульд 2021 оны нэмэлт өөрчлөлтөөр 10 дугаар зүйлийн 10.5⁸ дахь заалтыг оруулснаар ХНХС, Сангийн сайдын А/23, А/27 дугаар тушаалаар “Хүүхдийн хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив”-ыг баталж хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөлт, зарцуулалтыг тодорхой тайлагнах нөхцөл 2022 оноос бүрдсэн байна.
- 2.1.6 “Хүүхдийн хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив”-аар цахим мэдээллийн сан дахь тохиолдол (кейс)-ийн тоо, үзүүлсэн үйлчилгээний чанарын үнэлгээнд үндэслэн олгохоор заасан хэдий ч цахим мэдээллийн сан хөгжүүлэлт, ашиглалтгүйгээс шалтгаалан хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлсэн мэдээллийг оруулдаггүй, аргачлалыг зөрчин санхүүжилтийг олгожээ.

⁸ 10.5.Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журмыг хүүхэд хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, үйлчилгээний зардлын норматив, санхүүжүүлэх аргачлалыг хүүхэд хамгааллын болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

2.2 Шуурхай тусламж, хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний санхүүжилтийг зардлын аргачлал, нормативыг үндэслэн олгохгүй байна.

2.2.1 ХГБХХГ нь хүүхэд хамгааллын үйлчилгээний зардалд төлөвлөсөн санхүүжилтийг 2019-2022 онуудад 100.0 хувь, 2022 онд 90.5 хувь, 2023 онд 94.0 хувийг тус тус зарцуулжээ. Хүүхэд хамгааллын санхүүжилт 2019 оныг 2023 онтой харьцуулахад 39.0 хувиар өссөн үзүүлэлтэй байна.

Хүснэгт 3. Хүүхэд хамгааллын зардлын төсвийн гүйцэтгэл /сая төгрөгөөр/

Он	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйцэтгэлийн хувь
2019	67.5	67.5	100.0
2020	42.1	42.1	100.0
2021	38.0	38.0	100.0
2022	98.8	89.3	90.5
2023	109.3	102.8	94.0

Эх сурвалж: ХГБХХГ-ын санхүүгийн тайлан, 2019-2023 он

2.2.2 Хүүхэд хамгааллын зардлаас 2019-2023 онд байгууллагын үйл ажиллагааны урсгал зардалд 26.2 сая төгрөгийг зарцуулсан байна.Тухайлбал:


- Авто тээврийн хэрэгсэл худалдан авахад 9.5 сая төгрөг;
- Байгууллагын албан хаагчдад олгох нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 6.2 сая төгрөг;
- ХГБХХГ-ын цахим сайтын хөгжүүлэлтийн зардалд 4.3 сая төгрөг;
- ХГБХХГ-ын албан хаагчдын сайн туршлага судлах сургалт арга хэмжээний томилолт, замын зардалд 4.0 сая төгрөг;
- Авто тээврийн хэрэгслийн сэлбэг, засварын зардалд 2.4 сая төгрөг.

2.2.3 ХГБХХГ-ын үйл ажиллагаанд хүүхэд хамгааллын зардлын төсвөөс зарцуулж байгаа нь төсвийн үр өгөөжийг бууруулах эрсдэлтэй байна.

2.2.4 Хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх зардлаас сургалт зохион байгуулах зардалд 2019 онд 10.8 сая төгрөг, 2021 онд 1.2 сая төгрөг, нийт 12.0 сая төгрөгийг зарцуулсан боловч сургалтад оролцогчдын ирцийн бүртгэлгүй, тараах материал олгосон жагсаалтгүй, сургалтын тайлангүй байгаа нь төсвийн үр ашгийг бууруулсан байх эрсдэл байна.

Дүрслэл 2. Хүүхэд хамгааллын зардлын ил байдал

2.2.5 ХГБХХГ-ын шилэн данс цахим системд 2019-2023 онуудад батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэл, хүүхэд хамгааллын зардлыг зарцуулах тушаал шийдвэрийг мэдээлсэн байдал жил ирэх тусам сайжирсан бөгөөд 2023 оны байдлаар 99.0 хувьтай байна.



Эх сурвалж: Шилэн данс

2.2.6 ХГБХХГ-ын цахим сайтын хөгжүүлэлтэд 2022 онд хүүхэд хамгааллын зардлаас 3.8 сая төгрөгийг зарцуулж “Санхүүгийн ил тод байдал” цэсээр хүүхэд хамгааллын зардлын зарцуулалтыг мэдээлэх боломж бүрдсэн боловч уг цэсэд мэдээллийг байршуулаагүй байна.

2.2.7 Аймгийн хэмжээнд 2019-2023 онд НҮБ-ийн Хүүхдийн сангаас 3,170.7 сая төгрөг, Дэлхийн зөн ОУБ-аас 386.7 сая төгрөг, 2023 онд Японы хүүхдийг ивээх сангаас 109.0 сая төгрөг, нийт 3,666.4 сая төгрөгийг хүүхэд хамгааллын зардлын санхүүжилт олгосон байна.

Хүснэгт 4. ОУБ-аас хүүхэд хамгаалалд зарцуулалт /сая төгрөгөөр/

ОУБ-ын нэр	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он	Нийт
НҮБ-ийн Хүүхдийн сан	378.9	1205.5	615.6	875.3	95.4	3,170.7
Дэлхийн зөн ОУБ	191.0	68.4	10.3	42.3	74.7	386.7
Японы хүүхдийг ивээх сан	-	-	-	-	109.0	109.0
Нийт дүн	569.9	1273.9	625.9	917.6	279.1	3,666.4

Эх сурвалж: ОУБ, Төрийн байгууллагуудаас ирүүлсэн судалгаа

- 2.2.8 ОУБ-ууд урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд сургалт, нөлөөллийн ажлын санхүүжилтийг төрийн байгууллагуудад олгож, зардлын зарцуулалтад орон нутгаас хяналтыг хэрэгжүүлж байна. Харин хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийг гэрээний дагуу гүйцэтгэгчид шууд олгодог байна. Тухайлбал: НҮБ-ын Хүүхдийн сангийн “Ус хангамж ариун цэвэр, эрүүл ахуйн үйлчилгээ” төслөөр цэцэрлэг, сургууль, эрүүл мэндийн байгууллагын ариун цэврийн байгууламж барих, солих, халуун ус, жорлон байгуулах, ундны усны ухаалаг төхөөрөмж, усан сан хийх зэрэг хөрөнгө оруулалтын ажлуудыг хийж, гүйцэтгэгч хуулийн этгээдэд санхүүжилтийг олгосон байна.
- 2.2.9 Хүүхэд хамгааллын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 4.1.2⁹-т заасны дагуу урьдчилан сэргийлэх, шуурхай тусламж, нөхөн сэргээх үйл ажиллагааг явуулж байгаа боловч хамтарсан багийн гишүүдийн мэдлэг, мэдээлэл дутмагаас “Хүүхэд хамгааллын үйлчилгээний зардлын норматив, санхүүжүүлэх аргачлал”-д зааснаар шуурхай тусламж, нөхөн сэргээх зардлыг ХГБХХГ-аас нэхэмжилж авахгүй байна.
- 2.2.10 ХГБХХГ нь 2022 онд 30 хамтарсан багт тус бүрд 4 удаагийн шуурхай тусламжийн үйлчилгээгээр, 2023 онд баг тус бүрд 3 удаагийн шуурхай тусламжийн үйлчилгээгээр тооцон санхүүжилтийг урьдчилан олгожээ. Шуурхай тусламжийн үйлчилгээний анхан шатны баримтыг үзэхэд 2022 онд 65 удаагийн шуурхай тусламжийн үйлчилгээний 2.8 сая төгрөгийн анхан шатны баримт дутуу, 2023 онд 11 удаагийн шуурхай тусламжийн үйлчилгээний 0.5 сая төгрөгийн анхан шатны баримт дутуу зөрчил илэрсэн.
- 2.2.11 Хүүхэд хамгааллын зардлаас тохиолдол гарсан тухай бүрд үзүүлсэн үйлчилгээний гүйцэтгэлээр санхүүжилтийг нэхэмжилдэггүй, урьдчилан зардлын нормативын дээд хэмжээгээр олгож байгаа нь төсвийг үр ашиггүй зарцуулах нөхцөлийг бүрдүүлж байна.
- 2.2.12 Хүүхэд хамгааллын үйлчилгээний зардлын зарцуулалтад мөрдөх “Хүүхдийн хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив”-ыг гэр бүлийн орчинд хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээний зардалд цалин, урамшуулал, тээвэр шатахуун, бичиг хэрэг, бичиг баримтжуулалт, холбон зуучлах зэрэгт санхүүжүүлэхээр баталсан байна. Тус зарцуулалтыг хянахад өмнөх онуудын жишгээр тусламж дэмжлэг хэлбэрээр олгосон нь баталсан нормативыг баримтлаагүй байна.
- 2.2.13 Түр хамгаалах байрны үйлчилгээг үзүүлж байгаа Монголын Улаан загалмай нийгэмлэг үндэсний хүмүүнлэгийн байгууллагын аймаг дахь салбарт “Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив”-ыг зөрчиж 2023 онд 1.9 сая төгрөгийг санхүүжүүлсэн байна.
- 2.2.14 Есөнбулаг сумын 10 хамтарсан багаас хүүхэд хамгааллын үйлчилгээ авсан хүүхдийн хувь хүний мэдээллийн нууцын хамгаалалт хангалтгүй, хамтарсан багийн гишүүд нууцын баталгаа гаргаагүй нь нууц алдагдах эрсдэлийг бий болгож байна.
- 2.2.15 Хүүхэд хамгааллын үйлчилгээний зардлыг 2019-2021 онд төсвийн зарцуулалтад баримтлах аргачлал, нормативгүйгээс гүйцэтгэлээр санхүүжүүлсэн байна.
- 2.2.16 Урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2023 оны зардлыг хүүхдийн тоон мэдээлэлд үндэслэн “Хүүхдийн хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив”-ын дагуу тооцоход 13.9 сая төгрөгийг төсөв гарахаар байна.

⁹4.1.2.“хүүхэд хамгаалал” гэж нийгмийн бүх орчинд хүүхэдтэй зүй бус харьцах, хүүхдийг хүчирхийлэл, мөлжлөгт өртөхөөс хамгаалах, нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн энэ хуульд заасан зарчмыг баримталсан цогц бодлого, үйл ажиллагаа, үйлчилгээг;

Хүснэгт 5. Урьдчилан сэргийлэх үйлчилгээний зардлыг нормативын дагуу тооцоолсон байдал сая төгрөгөөр

Эрсдэл ийн зэрэг өндөр хүүхдийн тоо	Аргачлал тооцсон өртөг	Хүүхдэд чиглэсэн хөгжил сургалт нөлөөллийн ажил	Нийт хүн амын тоо	Аргачлал тооцсон өртөг	Олон нийтэд чиглэсэн сургалт, нөлөөллийн зардал	Хамтарсан багийн тоо	Аргачлал тооцсон өртөг	Боловсон хүчин чадавжуул ах зардал	Нийт дүн	Батлагдсан төсөв	Шаардлагатай төсөв
521	0.0075	3.9	57328	0.000375	21.5	30	0.7055	21.2	46.6	32.7	13.9

2.2.17 Хүүхэд хамгааллын зардлын төсвийн гүйцэтгэлээр хамгаалах, нөхөн сэргээх зардлыг 2022 онд 6.1 сая төгрөг, 2023 онд 6.5 сая төгрөгөөр хэмнэсэн. Харин урьдчилан сэргийлэх зардлыг 2022 онд 2.4 сая төгрөгөөр, 2023 онд 15.4 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан нь төсвийг бодитой төлөвлөөгүйг харуулж байна.

БҮЛЭГ 3. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯНАЛТ, САЛБАР ХООРОНДЫН УЯЛДАА ХОЛБОО ХАНГАЛТГҮЙ БАЙНА.**3.1 Хүүхэд хамгааллын талаар хэрэгжиж буй үйл ажиллагаанд тавих хяналт хангалтгүй байна.**

- 3.1.1 Хүүхэд хамгааллын тогтолцоонд гэр бүл, боловсрол, эрүүл мэнд, цагдаа, соёл, спорт, хэвлэл мэдээлэл, онцгой байдлын газрын оролцоо хамтын ажиллагаа чухал бөгөөд эдгээр салбарын хүүхдийн эрхийг хамгаалахад чиглэсэн оролцогч талуудын үйл ажиллагааг үнэлж, дүгнэх нарийвчилсан аргачлал боловсруулах эрх зүйн зохицуулалт хууль тогтоомжид тусгагдаагүй нь салбар хоорондын уялдаа хангалтгүй түүнийг эрчимжүүлэх хөшүүрэг алдагдаж байна.
- 3.1.2 Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3¹⁰-т, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1¹¹-т, Хүүхэд гэр бүл хөгжил залуучууд хөгжлийн газрын даргын 2020 оны 11 дүгээр сарын А/240 тушаалын 3¹²-т ХГБХХГ нь хяналтыг хэрэгжүүлэхээр заасан хэдий ч Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилт, Хүүхдийн төлөө зөвлөл, хүүхдийн элч, хүүхдийн эрхийн үйл ажиллагаанд 2020 оноос хойш хяналт шалгалт хийгээгүй, цаашид авах арга хэмжээг төлөвлөх боломжгүй нөхцөл байдлыг үүсгэж байна.
- 3.1.3 НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенцын хэрэгжилтийн талаарх 5 дугаар тайлангийн илтгэлийг 2017 оны 5 дугаар сард НҮБ-ийн хүүхдийн эрхийн хорооны 75 дугаар чуулганаар хэлэлцүүлэн зөвлөмж хүлээн авсан бөгөөд энэ удаагийн зөвлөмж нь Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг анхаарахыг чухалчилсан байна.
- 3.1.4 Хүүхдийн эрхийн тухай конвенцын 44 дүгээр зүйлийн 1а¹³-д биелэлтийг тайлагнах үүрэг хүлээсний дагуу 2021 онд биелэлтийг ГБХЗХЕГ-т хүргүүлсэн байна.
- 3.1.5 Монгол Улсын Засгийн газрын “Ерөнхий төлөвлөгөө батлах тухай” 2016 оны 204 дугаар, 2023 оны 357 дугаар тогтоолоор харьяа нутаг дэвсгэртээ НҮБ-ын хүний эрхийн зөвлөлөөс өгсөн зөвлөмжийн дагуу арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг Засаг дарга нарт үүрэг болгосон байна.
- 3.1.6 Аймгийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр, Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөрт НҮБ-аас өгсөн зөвлөмжийг тусган хэрэгжилтийг хангаж ажиллаж байгаа боловч зөвлөмжийн биелэлтийг тайлагнаж, нэгтгэдэггүй байна.

¹⁰ 51.3-т Энэ хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно.

¹¹ 22.1-т Хүүхэд хамгааллын нөхцөл байдлыг тодорхойлох, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд үзүүлэх хариу үйлчилгээг үнэлэх зорилгоор хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь дараах хяналт, шинжилгээ, үнэлгээ хийнэ.

¹² Аймаг нийслэл сум дүүргийн хүүхдийн төлөө зөвлөл, Хүүхдийн эрхийн ажилтан, хүүхдийн элчийн тухай жил бүрийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээ хий ажлыг жил бүр байгууллагын төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлж байхыг аймаг, нийслэл, дүүргийн ажлын албаны даргад нарт үүрэг болгосугай.

¹³ Хүүхдийн эрхийн конвенцын 44 дүгээр зүйлийн 1а/тухайн оролцогч улсын хувьд Конвенц хүчин төгөлдөр болсноос хойш 2 жил, түүнээс дараа 5 жил тутам

- 3.1.7 Аймгийн хэмжээнд 2019-2023 онд хүүхэд хамгааллын чиглэлээр Олон улсын байгууллагуудаас дараах төсөл хөтөлбөр хэрэгжсэн байна. Үүнд:
НҮБ-ын Хүүхдийн сангаас: Ус хангамж ариун цэвэр орчин нөхцөл сайжруулах, эрүүл ахуйн үйлчилгээ, эрүүл хоол үйлдвэрлэл үйлчилгээ, Бигэр сумын дотуур байрны тавилга нийлүүлэх, Хантайшир-Эрдэм цогцолбор сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хэрэгсэл шинэчлэх төсөл,
Дэлхийн зөн ОУБ-аас: Хүүхэд хамгаалал-хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх, Эх, хүүхдийн эрүүл мэндийг сайжруулах төсөл,
Японы хүүхдийг ивээх сангаас: Дарив сумын Ерөнхий боловсролын сургууль, Есөнбулаг сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуультай хамтран "Хүүхэд хамгааллыг сайжруулах нь" төсөл тус тус хэрэгжиж байна.
- 3.1.8 НҮБ-ын Хүүхдийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн "Хүүхдэд ээлтэй Алтай" дэд хөтөлбөрийн үр дүнг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс хяналт шинжилгээ хийж 95.0 хувьтай дүгнэжээ. Дэлхийн зөн ОУБ, Японы хүүхдийг ивээх сангаас хэрэгжүүлж буй төслийн үр дүнг тооцож үнэлээгүй, хугацаа дуусаагүй байна.
- 3.1.9 Хүүхдийн эрхийг хамгаалах, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд иргэн, байгууллага, аж ахуйн нэгж бүрийн оролцоог хангах зорилгоор Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн "Хүүхэд хамгааллын чиглэлээр баримтлах бодлого, чиглэл батлах тухай" 03 дугаар тогтоолоор "Хүүхэд хамгааллын жишиг бодлого", "Эцэг эхийн зөвлөлийн ажиллах зөвлөмж"-ийг батлан ажиллаж байна.
- 3.1.10 ХГБХХГ нь байгууллагын дэргэдэх Эцэг эхийн зөвлөлийг жилд 1-2 удаа удирдлага арга зүйгээр хангаж, тэднээр дамжуулан тухайн байгууллага, аж ахуй нэгжид ажиллаж буй эцэг эхчүүд, хүүхдийн эрхийг хангахад чиглэсэн мэдээллийн хүртээмж нэмэгдсэн бөгөөд 2023 оны байдлаар 125 байгууллага Эцэг эхийн зөвлөл байгуулж үйл ажиллагаа явуулж байна.
- 3.1.11 Хүүхэд хамгааллын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1¹⁴ -т аймгийн Хүүхдийн төлөө зөвлөл нь хүүхэд хамгааллын бодлогод хяналт тавих чиг үүргийн хүрээнд 2022 онд 6 суманд хяналт шалгалт хийсэн гэх боловч анхан баримтаар нотлогдохгүй байна.
- 3.1.12 Хүүхдийн эрхийн тухай хуулийн 16 дугаар зүйлд Хүүхдийн төлөө үндэсний болон орон нутгийн зөвлөлийн үүрэг, чиглэлийг хуульчилсан байдаг.
- 3.1.13 Аймгийн Засаг даргын 2019 оны А/523 дугаар захирамжаар орон нутгийн хэмжээний хүүхдийн хөгжил, хамгааллын чиглэлээр бодлого боловсруулж, хэрэгжилтийг хангах салбар дундын уялдаа холбоо, хамтын ажиллагааг бэхжүүлэх үүрэг бүхий Хүүхдийн төлөө зөвлөлийн бүрэлдэхүүнийг байгуулж, ажиллах дүрэм, чиг үүргийг баталсан байна.
- 3.1.14 Аймгийн хүүхдийн төлөө зөвлөл нь жилд 1-2 удаа хуралдаж оны онцлох хүүхэд шалгаруулах, дараа жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцсэн байна.
- 3.1.15 Зөвлөлийн 2019-2020 оны ажлын төлөвлөгөө, тайлангүй, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар тайланг хэлэлцүүлдэггүй, хүүхэд хамгаалал, хөгжлийн үйл ажиллагааны талаар холбогдох төрийн байгууллагад чиглэл өгч ажиллаагүй нь аймгийн хэмжээнд хүүхэд хамгааллын цогц үйлчилгээ бүрэн ханган ажиллаагүй байна.
- 3.1.16 Аймгийн ХГБХХГ нь Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журам"-д бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, байгууллагын үйл ажиллагаа багтана заасны дагуу хүүхэд хамгааллын бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүнг жил бүр үнэлж холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.

¹⁴ Монгол Улсын хэмжээнд Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл, орон нутагт хүүхдийн төлөө зөвлөл нь хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтэд хяналт тавина гэж заасан байдаг.

Хүснэгт 6. Бодлогын хэрэгжилт 2019-2023 дунджаар

№	Арга хэмжээ	Хүүхэд хамгааллын чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ	Биелэлтийн дундаж хувь
1	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт	15	86.0
2	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	17	85.4
3	Аймаг эдийн засаг, нийгмийн хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт	9	89.1
4	Улс эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт	3	85.0
5	Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал	3	100.0
	Нийт дүн	47	89.1

Эх сурвалж: ХХБХХГ-ын 2019-2023 оны бодлогын баримт бичиг хэрэгжилтээс

3.1.17 Аймгийн хэмжээнд дээрх бодлогын баримт бичигт хүүхдэд чиглэсэн 131 арга хэмжээ хэрэгжүүлснээс 35.8 хувь буюу 47 арга хэмжээ нь хүүхэд хамгааллын үйл ажиллагаатай холбоотой байна.

3.1.18 Хүүхэд хамгааллын талаарх олон нийтийн ойлголт, тандалтын асуумжаар хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлдэг байгууллага, үйлчилгээг олонх нь мэддэг, төрөөс баримталж буй бодлого, үр дүнг “дунд” түвшинд байна гэж үнэлжээ.

Орон нутагт хэрэгжсэн дэд хөтөлбөрөөс нийгэмд гарсан эерэг талыг дурдвал:

- ❖ “Хүүхдэд ээлтэй Алтай” дэд хөтөлбөрийн хүрээнд 2,610.0 сая төгрөгийн санхүүжилтээр 12 сургууль, 8 цэцэрлэг, 10 эрүүл мэндийн байгууллага, 4 сумын төвийн ариун цэврийн байгууламж, нүхэн жорлонг шинэчлэх, 1 сургууль, 2 цэцэрлэг, 17 сумын ундны усны худаг, төхөөрөмжийг шинэчлэх байгуулах, 3 сумын төв халуун ус шинэчлэн байгуулах ажлыг хийж хүүхэд, ард иргэдийн эрүүл аюулгүй амьдрах орчин бүрдүүлсэн томоохон үр дүнтэй ажил болсон байна.
- ❖ “Амны хөндийн эрүүл мэнд” дэд хөтөлбөрийн хүрээнд аймгийн 9216 хүүхдийг урьдчилсан үзлэгт хамруулж, 1369 хүүхдийн шүдийг эмчлэн эрүүлжүүлжээ.

3.2 Хүүхэд хамгааллын оролцогч талуудын хэрэгжүүлж буй арга хэмжээгээр нийгэмд эерэг нөлөөлөл бий болж байгаа хэдий ч гэр бүлийн орчин дахь зөрчил буурахгүй байна.

3.2.1 Хүүхэд хамгааллын тухай хуулийн үндсэн зарчмын хүрээнд гэр бүл төвтэй хүүхэд хамгааллын үйлчилгээг дэмжих бодлого баримталж хэдий ч аймгийн цагдаагийн газар, эрүүл мэндийн газрын сүүлийн 5 жилийн тоон үзүүлэлтээс харахад дараах байдалтай байна. Тухайлбал:

- Хүүхдийн тусламжийн 108 утсанд 318 дуудлага мэдээлэл бүртгэгдэж, 121 дуудлага буюу 38.0 хувь нь гэр бүлийн орчинд үйлдэгдсэн;
- Гэмт хэрэгт холбогдсон хүүхэд 74;
- Гэмт хэргийн улмаар хохирсон хүүхэд 102;
- Гэр бүлийн орчинд үйлдэгдсэн гэмт хэргийн тоо 56;
- Гэр бүлийн орчинд үйлдэгдсэн зөрчлийн тоо 378 ;
- Хүчирхийлэлд өртөж эрүүл мэндийн төвөөр үйлчилгээ авсан хүүхэд 17;
- Бэлгийн замын дамжсан халдвар авсан хүүхэд 5;
- Жирэмсэлсэн хүүхэд 40;
- Үр хөндөлт хийлгэсэн хүүхэд 16;
- Жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгсэл тавиулсан хүүхэд 11;
- Жирэмсний тестээр үзүүлсэн /бэлгийн хавьталд орсон/-312 хүүхэд бүртгэгдсэн тоон мэдээлэл байна.

- 3.2.2 Гэр бүлийн орчинд эцэг, эхээс хүүхдэд тавих анхаарал халамж муу, үл хайрах, гэр бүл салалт, хүүхдийн дэргэд архи дан согтуурснаас хүүхдийн хүмүүжил, ухамсарт нөлөөлж дээрх эрсдэлт нөхцөл үүсгэх шалтгаан болж байна.
- 3.2.3 Гэр бүлийн орчин дахь хүүхэд хамгаалал чиглэлээр эцэг эх, асран хамгаалагчаас судалгаа авахад 769 эцэг эхээс 44.2 хувь нь хүүхэдтэйгээ ярилцаж цаг гаргадаггүй, 44.7 хувь нь хүүхдийн сэтгэл зүй, эрүүл мэндэд анхаарал тавьж чаддаггүй, 16.6 хувь нь хүүхдийн дэргэд архи согтууруулах ундаа, тамхи хэрэглэдэг гэж хариулсан бол 91.2 хувь нь хүүхдээ хэнтэй найзалж нөхөрлөж байгааг мэддэг гэж хариулсан.
- 3.2.2 Боловсролын байгууллага нь суралцаж байгаа хүүхэд бүрийг сургуулийн орчинд бие мах бодийн шийтгэл, сэтгэл зүйн болон үе тэнгийнхний дарамт, үл хайхрах байдал, гэмт хэрэг, зөрчил, хорт зуршилд өртөхгүй байхаас хамгаалах үүрэгтэй.
- 3.2.3 Аймгийн хэмжээнд 2019-2023 онд ерөнхий боловсролын сургуульд нийт 58588 хүүхэд, сургуулийн өмнөх боловсролын байгууллагад нийт 19835 хүүхэд элсэн орсон байна. Дотуур байранд 2023 оны байдлаар 1261 хүүхэд амьдарч байна.
- 3.2.4 “Боловсролын байгууллагын сургалтын орчин, дотуур байранд хүүхэд хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх журам”, ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дотуур байрны орчин үйлчилгээ MNS6781:2019 стандартын дагуу нөхцөл байдлыг үнэлэхэд:
- Ерөнхий боловсролын 21 сургуулийн дотуур байрууд нь галын болон аюулгүй байдлын дохиоллын системгүй, барилга бүхэлдээ агааржуулалтын системгүй, аянга зайлуулагчгүй, цахилгаан далд холболтгүй, угаалга хатаалга, индүүдлэгийн болон эрэгтэй эмэгтэй тусдаа усанд орох өрөөгүй, бага насны болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан угаалтуур шүршүүргүй, ариун цэврийн өрөө стандартын шаардлага хангаагүй байна. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний ажилчдын гар угаах, ариутгах орчин нөхцөл эрүүл ахуйн шаардлагад нийцээгүй, хооллох хэрэгслийг угаах, хатаах, ариутгах машингүй, улирал тутам хортон шавж, мэргэчийн устгал, халдваргүйжүүлэлт, ариутгал хийгддэггүй байна. /Хавсралт №1/
 - Боловсролын салбарт камергүй 5 ерөнхий боловсролын сургууль, камерын бичлэгийг 30 хоногоос доош хугацаанд хадгалдаг 8 ерөнхий боловсролын сургууль, 5 хүүхдийн цэцэрлэг байна. /Хавсралт №2/
 - Мэргэжлийн боловсролын сургуулийн дотуур байр нь шүршүүрийн өрөөгүй, гал тогоогүй, галын болон аюулгүй байдлын дохиололгүй, эмнэлгийн анхан шатны тусламжийн хайрцаггүй, өрөөний хаалга цоожгүй, хувцасны шүүгээ сандалгүй, 20 хүүхэд тутам-1 шүршүүргүй, эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт тогтмол хамрагдуулдаггүй зэрэг нь стандартын шаардлагад нийцэхгүй, орчин нөхцөл муу байна.

Зураг 1. Мэргэжлийн боловсролын сургуулийн дотуур байрны орчин нөхцөл



- 3.2.5 Сургууль орчин дахь хүүхэд хамгааллын талаарх судалгаанд 75.4 хувь нь сургуулиас сургалт нөлөөллийн ажил байнга хийдэг, 76.3 хувь дээрэлхэлт буурсан, 34.4 хувь нь сургууль орчинд сэтгэл зүй үе тэнгийн дээрэлхэлт байдаг, 25.6 хувь нь ойр дотно найз нөхөд дээрэлхэлтэд өртөж байсан, 32.2 хувь нь сэтгэл зүйн зөвлөгөө авах үе тулгардаг, 18.8 хувь нь сэтгэл зүйн зөвлөгөө авсан, 4.4 хувь архи тамхи хэрэглэж үзсэн, 31.7 хувь нь багш бие мах бодь сэтгэл зүйн шийтгэл үзүүлдэг гэж хариулжээ.
- 3.2.6 Дээрх судалгаанд оролцсон 410 хүүхдээс 352 хүүхэд буюу 85.9 хувь нь 12-15 насны хүүхэд байна. Судалгаанаас харахад хүүхдүүдэд үе тэнгийнхний болон сэтгэл зүйн дээрэлхэлт далд хэлбэрээр байдаг нь харагдаж байна.
- 3.2.7 Сургуулийн нийгмийн ажилтан нь мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан, 2022 оноос шинээр аймгийн төвийн 5, сумдын 6 ерөнхий боловсролын сургуульд сэтгэл

- зүйчтэй болсон нь сургуулийн орчин дахь хүүхэд хамгааллын үйлчилгээнд эерэг нөлөөлөл үзүүлж байна.
- 3.2.8 Аймгийн хэмжээнд 2019-2023 онд 7 хичээлийн байр, 3 дотуур байр, 1 биеийн тамирын заал, 6 цэцэрлэг, 2 цэцэрлэгийн өргөтгөл шинээр ашиглалтад орсноор хүүхдийн сурч хөгжих, хамгаалах орчин нөхцөл сайжирсан байна.
- 3.2.9 Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2015 оны А/152 дугаар тогтоолоор хүүхэд харах үйлчилгээг зохион байгуулах журам, хүүхэд харах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 6540-2015 стандартын дагуу аймагт үйл ажиллагаа явуулж байгаа “Жаргалын төв” хүүхэд харах төвийн ажилчид нууцын гэрээгүй байгуулаагүй, гар угаах угаалтуур, суултуур ажилчид хүүхэд дундаа нэг, аюулгүй байдлын төхөөрөмжгүй, галын дүн шинжилгээ хийлгээгүй, анхан тусламжийн үйлчилгээ үзүүлэх эмийн хайрцаггүй, хууль ёсны төлөөлөгчөөс хүлээн авч, хүлээлгэж өгсөн болон ажилчид хүүхэд хамгаалах бодлогыг судалж зөвшөөрсөн, баталгаажуулсан баримтгүй, халаалтын хэсэгт хүүхэд унаж бэртэхээс хамгаалсан хаалтгүй, өдөр тутмын хоолны менюгүй зэрэг нь стандартын шаардлагад нийцэхгүй, холбогдох байгууллагаас тавих хяналт хангалтгүй байна.
- 3.2.10 Аймгийн нэгдсэн эмнэлгийн өсвөрийн үеийн кабинетаар эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авсан хүүхдийн тоо 5 жилд 10009, үүнээс 2023 онд 3345 хүүхэд байгаа нь 2019 оноос хойш 9.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна.
- 3.2.11 Эрүүл мэндийн байгууллагуудын эмч, нийгмийн ажилтан нь хамтарсан багт гишүүнээр оролцож кейс тохиолдол бүрд тохирсон эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна.

Хүснэгт 7. Эрүүл мэндийн салбарын хамтарсан багийн тоон судалгаа

Үзүүлэлт	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он	Нийт
Хамтарсан багийн дуудлагаар үзүүлсэн үйлчилгээний тоо /хүүхэд/	32	23	17	5	4	81
Хамтарсан багийн дуудлагаар үзүүлсэн үйлчилгээний тоо /том хүн/	13	23	25	0	2	63
Нийт	45	46	42	5	6	144

Эх сурвалж: Эрүүл мэндийн газрын жилийн эцсийн тайлан мэдээ 2019-2023 он

- 3.2.12 Эрүүл мэндийн байгууллага эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд үзүүлсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг холбогдох байгууллагад мэдээлэх үүргийг хэрэгжүүлэхгүй байна.
- 3.2.13 Хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэхэд эрүүл мэндийн салбарын хамтын ажиллагааг сайжруулах, эмч мэргэжилтнүүдийнхээ хүүхэд хамгааллын талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.
- 3.2.14 Хүүхэд эцэг эхийн хяналтгүйгээр олон нийтийн цахим сүлжээг ашигласнаар хүчирхийлэл, залилан мэхлэлтэд өртөх, санхүүгийн болон бие сэтгэлийн хохирол амсах, гүтгэлэг, доромжлолд өртөх, бэлгийн болон сэтгэлзүйн дайралтад өртөх, бодит бус, ухуулгад автах, аюултай хүмүүстэй харилцаа тогтоох эрсдэл үүсгэж байгаа нь цахим орчин дахь хүүхдийн хамгааллын асуудал нэн түрүүн тулгамдаж байна.
- 3.2.15 Аудитаар 769 эцэг эх, асран хамгаалагчаас судалгаа авахад хүүхдийнхээ цахим хэрэглээг 16.1 хувь нь хянаж чаддаггүй, 37.3 хувь нь заримдаа хянадаг, 71.6 хувь нь цахим хэрэглээг хянах боломжтой аппликейшн мэдэхгүй гэсэн хариултыг өгчээ.
- 3.2.16 Иймд хэвлэл мэдээлэл, цахим орчин дахь хүүхдийн хөгжил, хүмүүжил, төлөвшилд сөрөг нөлөөтэй зураг, кино, дүрс бичлэг болон мэдээ, мэдээлэл, контентыг хянах, хаах зохицуулалтыг хууль эрх зүй, технологийн түвшинд боловсронгуй болгох хэрэгцээ байна.
- 3.2.17 Холбогдох байгууллагуудаас цахим орчин дахь хүүхэд хамгаалал, гэмт хэрэг урьдчилан сэргийлэх сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж байгаа хэдий ч цахим орчны хэрэглээ хурдацтай өсөж байгаа цаг үед урьдчилан сэргийлэх арга хэмжээний тоог нэмэгдүүлж, түүнд тавих хяналтын системийг сайжруулах шаардлагатай байна.

- 3.2.18 Хүүхэд хамгааллын тухай хуулийн 9 дүгээр зүйл, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга, Соёл урлагийн газрын даргын 2022 оны А/242, А/76 дугаар хамтарсан тушаалаар “Соёл, спорт, олон нийтийн үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулах, эрхийг хамгаалах” тухай журмыг баталсан байна.
- 3.2.19 Спортын олон нийтийн арга хэмжээ үйл ажиллагаанд хүүхдийг оролцохдоо хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрөл, эрүүл мэнд, гэнэтийн ослын даатгалд хамруулдаг гэсэн боловч анхан шатны баримтаар нотлогдохгүй, зарим тэмцээнд эмчгүй оролцуулдаг, зохион байгуулж буй үйл ажиллагааны удирдамжид хүүхдийн эрхийн хамгаалал, аюулгүй байдлыг хангах асуудлыг тусгадаггүй, мөн удирдамжийг ХГБХХГ-т хүргүүлдэггүй зэрэг нийтлэг зөрчил байна.
- 3.2.20 Засгийн газрын 2011 оны 303 дугаар тогтоолын хавсралтаар Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах үндэсний хөтөлбөрийг боловсруулан батлахдаа хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааны чиглэлээр “Хурдан морины уралдаанч хүүхдийн хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлыг хангах үндэсний стандартыг боловсруулан баталгаажуулж мөрдүүлэх”-ээр зааж хүүхдийн хурдны морь унах, уралдах асуудлыг “хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэр” гэх хөтөлбөрт багтаан үзсэн байна.
- 3.2.21 Эмнэлгийн байгууллагаар 2019-2023 онд нийт 173 хүүхэд мориноос унаж эрүүл мэндийн үйлчилгээ авсан байна. Үүнээс 3 хүүхдийн амь нас эрсэдсэн байна.

Хүснэгт 8. Хурдан морь унаач хүүхдийн судалгаа

Үзүүлэлт	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он	Нийт
Хурдан морь унаач хүүхэд	636	639	621	628	633	3157
Мориноос унасан хүүхдийн тоо	33	41	40	33	26	173
Гэмтэл бэртэл авч эмнэлгийн байгууллагаар эмчлүүлсэн хүүхдийн тоо	33	41	40	33	26	173
Нас барсан хүүхдийн тоо	-	1	-	2	-	3
Даатгалд хамрагдсан хүүхдийн тоо	389	428	432	161	402	1812
Даатгалаас нөхөн олговор авсан хүүхдийн тоо	-	-	-	-	-	-

Эх сурвалж: Эрүүл мэндийн газрын жилийн эцсийн тайлан мэдээ 2019-2023 он

- 3.2.22 ХГБХХГ нь унаач хүүхдийн бүртгэлийг абле цахим системээр хийдэг бөгөөд гарааны бүртгэлийг интернэт орчингүйгээс шалтгаалан системд баталгаажуулах боломжгүй байна. Цаашид хурдан морины уралдааныг хянах интернэт орчин бүрдүүлэхэд шаардагдах төсвийг шийдвэрлэх хэрэгцээ байна.
- 3.2.23 Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 201 дүгээр тогтоолоор баталсан “Онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах, тусламж, дэмжлэг үзүүлэх журам”-д боловсрол, гэр бүл, эрүүл мэнд, цагдаа, онцгой, орон нутгийн байгууллагын гамшгаас хамгаалах харилцааг зохицуулжээ.
- 3.2.24 Аймгийн Онцгой байдлын газраас журамд заасны дагуу хүүхэд хамгааллын мэргэжлийн ангид гамшгаас хамгаалах мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, удирдлагаар хангаж ажилласан байна.
- 3.2.25 Хүүхдийг авран хамгаалах хүүхдийн аюулгүй байдлыг хангах сургалтаар 35 байгууллагад 42 удаагийн сургалтаар 2540 хүүхэд, эцэг, эх, асран хамгаалагч нарт заавар зөвлөгөө өгсөн байна.
- 3.2.26 Засгийн газрын 2020 оны 190 дүгээр тогтоолоор баталсан “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журам”-ын 1.2¹⁵, 2.2¹⁶- дахь заалтын дагуу 2 ерөнхий боловсролын сургуульд тойм үнэлгээ, 5 ерөнхий боловсролын сургуульд эрсдэлийн үнэлгээ хийсэн байна.

¹⁵ 1.2. Эрсдэлийн үнэлгээний зорилго нь хүн ам, тодорхой нутаг дэвсгэр, хуулийн этгээд, барилга байгууламжид тохиолдож болзошгүй гамшгийн эрсдэлийг тодорхойлох, түүнийг бууруулах үйл ажиллагааг төлөвлөхөд оршино

¹⁶ 2. Эрсдэлийн үнэлгээг энэ журмын 1.3-т заасан түвшинд 3 жил тутам, эсхүл нөхцөл байдлаас хамааран тухай бүр хийнэ.

3.3 Хамтарсан багийн гишүүдийн ажлын чиг үүргийн хэрэгжилт хангалтгүйгээс эрсдэлт нөхцөлд орсон хүүхдэд үзүүлэх хариу арга хэмжээг бүрэн үзүүлдэггүй, салбар хоорондын уялдаа холбоо хангалтгүй байна.

3.3.1 Монгол Улс Хүүхдийн эрхийн олон улсын конвенцод нэгдсэн үүргийг аймгийн хэмжээнд тайлагнаагүй, НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооноос ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийг гарган Хүүхдийн эрхийн хороонд хүргүүлсэн байна.

3.3.2 НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооноос ирүүлсэн дүгнэлт зөвлөмжид төсөв нөөцийн хуваарилалт, бизнесийн салбар ба хүүхдийн эрх, ялгаварлан гадуурхахгүй байх, гэр бүлийн орчин, орчны эрүүл мэнд, эдийн засгийн мөлжлөг, хүүхдийн хөдөлмөр, хурдан морь унаач хүүхдийн асуудалд арга хэмжээ авахыг зөвлөсөн.



Энэ хүрээнд аймгийн ХГБХХГ нь Монгол Улсын Засгийн газрын 57 дугаар тогтоолд заасны дагуу хориглосон хугацаанд хурдан морины уралдаан, үсэргээ, сунгаа зохион байгуулсан 5 тохиолдлыг илрүүлэн уралдааныг зохион байгуулсан 6 иргэнийг Зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага тооцож хэрэгжилтийг хүргүүлсэн байна.



3.3.3 Монгол Улсын хувьд Хүүхдийн Төлөө Үндэсний газраас хүүхдийн тусламжийн утасны үйлчилгээг 2005 онд “Дотно утас 1979” нэртэйгээр анх нээн ажиллуулж эхэлснээс хойш шинэчлэлт сайжруулалтыг хийж 2014 оноос “Хүүхдийн тусламжийн 108” утас нэртэйгээр ажиллаж байна.

3.3.4 Хүүхэд хамгааллын талаарх олон нийтийн ойлголт, тандалтын асуумжаар “Хүүхдийн тусламжийн 108” утсыг ихэнх нь мэддэг гэсэн хариулт өгсөн байгаа нь эрсдэлт нөхцөлд өртсөн хүүхдэд шуурхай арга авах боломж бүрджээ.

3.3.5 Хүүхдийн тусламжийн 108 утасны хариу үйлчилгээг орон нутгийн хэмжээнд 2018 оноос Хүүхдийн хөгжил хамгааллын албаны ахлах мэргэжилтэн, 2020 оны 4 дүгээр сараас хүүхдийн эрхийн улсын байцаагч хариуцан ажиллаж байна.

3.3.6 Хүүхдийн тусламжийн 108 утасны системд 2020 оны 5 дугаар сард шинэчлэл хийсэнтэй холбоотойгоор өмнөх онуудын мэдээлэл бүрэн татагдаагүй байна.

3.3.7 Хүүхдийн тусламжийн 108 утсанд 2019-2023 онуудад 318 дуудлага ирж, дуудлага мэдээллийг харьяаллын дагуу холбогдох хамтарсан баг, нийгмийн ажилтанд тухай бүр шилжүүлжээ.

Хүснэгт 9. Хүүхдийн тусламжийн 108 утасны дуудлага

Утга	2019 он	2020 он	2021он	2022 он	2023 он	Нийт
Дуудлагын тоо	37	62	76	67	76	318
Мэдээллийг хамтарсан багт цаг тухайд нь мэдээлсэн	37	62	76	67	76	318
Кейс нээж шийдвэрлэсэн	0	4	33	36	42	115
Хамрагдсан хүүхдийн тоо	34	58	93	68	94	347

Эх сурвалж: ХГБХХГ-аас ирүүлсэн судалгаа

3.3.8 Ирсэн дуудлагын 272 нь хүүхэд хамгаалалтай холбоотой, 46 нь зөвлөгөө хүссэн дуудлага байна. Дуудлагыг хүчирхийллийн төрлөөр нь авч үзвэл бие махбодын 94, сэтгэл санааны 68, үл хайхрах 52, бэлгийн хүчирхийлэлд 23, бусад хүчирхийлэлд 19, үе тэнгийн хүчирхийлэлд 16 хүүхэд өртсөн, ирсэн дуудлагыг орчны ангиллаар авч үзвэл олон нийтийн арга хэмжээ, үйлчилгээний газарт 146, гэр бүл дэх 121, боловсролын салбарт 42, эрүүл мэндийн салбарт 2, хэвлэл, мэдээлэл, цахим орчинд 2, бусад үйлдэгдсэн гэж 2 дуудлага иржээ.

Дүрслэл 3. Хүүхдийн тусламжийн 108 утасны дуудлага төрлөөр



Эх сурвалж: Хүүхдийн тусламжийн 108 утасны цахим системийн 2019-2023 оны тайлан

- 3.3.9 Хүүхдийн тусламжийн 108 утсанд ирсэн дуудлага мэдээллийг шийдвэрлэхдээ гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээ, хамтарсан багийн төлөвлөгөө зэргийг харгалзан үзэхгүй байна.
- 3.3.10 Нийгмийн ажилтан ирсэн дуудлага мэдээллийг хүлээн авч яаралтай үед нэн даруй, бусад нөхцөлд 72 цагийн дотор хамгааллын үйлчилгээг хамтарсан багийн төлөвлөгөөний дагуу үзүүлж, үйлчилгээ, кейс шийдвэрлэлтийн нотлох баримтыг цахим системд бүрэн оруулахгүй байна. Тухайлбал:

- Цахим системийн мэдээллээс бие мах бодын хүчирхийлэлтэй холбоотой ирсэн дуудлагыг түүвэрлэхэд дуудлагын дагуу үзүүлсэн үйлчилгээг 2019-2021 онд цахим системийн шинэчлэлтэй холбоотой оруулаагүй, сүүлийн онуудад дутуу оруулсан байна.
- Хүүхдийн тусламжийн 108 утсанд ирсэн дуудлагыг хүлээн авч тухай бүр холбогдох сум, албан тушаалтанд шилжүүлдэг боловч нөхөн сэргээх үйлчилгээнд шаардлагатай хүүхдийг хамруулсан эсэх нь тодорхойгүй, эргэх холбоотой ажиллахгүй, зарим тохиолдолд дуудлагыг явцын тэмдэглэл үйлдэн хааж байна.

- 3.3.11 Хүүхдийн тусламжийн утсанд ирсэн дуудлагыг хүлээн авч тухай бүр холбогдох сум, албан тушаалтанд шилжүүлдэг боловч нөхөн сэргээх үйлчилгээнд шаардлагатай хүүхдийг хамруулсан нь тодорхойгүй, эргэх холбоотой ажиллахгүй, зарим тохиолдолд дуудлагыг явцын тэмдэглэл үйлдэн хааж байгаа нь цахим системд өөрчлөлт хийх зайлшгүй шаардлага үүсэж байна.
- 3.3.12 Аймгийн хэмжээнд 2019-2023 онуудад хөдөөгийн 18 сум, 2 тосгон, Есөнбулаг сумын 10 багт хүүхэд хамгааллын хамтарсан багийг байгуулан ажиллаж байгаа бөгөөд үйл ажиллагааны тайлан, тэмдэглэлийг ХГБХХГ нэгтгэн хүлээн авч хяналт үнэлгээ хийгээгүйгээс нэгтгэсэн тоо мэдээллийн сангүй байна.
- 3.3.13 Аудитаар 30 хамтарсан багаас 129 кексийг түүвэрлэхэд хүүхдийн эрсдэлт нөхцөл байдлын үнэлгээ хийгээгүй, хамтарсан баг хуралдаж төлөвлөгөө батлаагүй, холбогдох байгууллагад холбон зуучлаагүй, хүүхэд, гэр бүлийн нөхцөл байдал сайжирсан эсэхэд хяналт, үнэлгээ хийгээгүй, эргэх холбоотой ажиллаагүй, хувийн хэргийг журмын дагуу хаагаагүй байна.
- 3.3.14 Хамтарсан баг нь хүүхдийг гэр бүлийн болон нийгмийн бусад орчинд хүчирхийлэл, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, мэдээлэл хүлээн авах, илрүүлэх, шалгах, хүчирхийллийг таслан зогсоох, аюулгүй байдлыг хангах, хамгаалах, хариу

үйлдэл үзүүлэх чиг үүрэг бүхий орон нутгийн удирдлага, мэргэжилтнүүдээс бүрдсэн баг мэргэжлийн үйлчилгээний стандартын дагуу ажиллаж байгааг нотлох баримт материалууд дутмаг, жилийн ажлын төлөвлөгөөгүй, зарим хамтарсан багууд тухайн онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний үр дүнг бодитой тооцоогүй байна.

3.3.15 ХГБХХГ-аас жилд 1-2 удаа явуулын үйлчилгээгээр сумдад ажиллаж сумдын хамтарсан баг, нийгмийн бодлого хариуцсан мэргэжилтэнд мэдээлэл, арга зүйн зөвлөгөө өгч байгаа ч дараах бэрхшээлтэй асуудлууд байна. Үүнд:


- Сум, багийн дарга нар ажлын чиг үүрэг, хариуцлагаа ойлгохгүйгээс ажилд туслалцаа үзүүлэх, чин сэтгэлээсээ хандах нь бага;
- Сумын нийгмийн бодлого хариуцсан мэргэжилтэн мэргэжлийн бус, тогтвор суурьшилгүй ажиллаж байгаагаас хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний чадамж муу;
- Хамтарсан багийн гишүүд болох Засаг дарга, нийгмийн ажилтан, эмч, цагдаа тус бүр өөрийн мэргэжлийн байгууллагад харьяалагддаг бөгөөд гишүүдийн ажил үүргийн хуваарьт тус багт ажиллах талаар заалтгүй, хүүхэд хамгааллын асуудал хариуцсан байгууллагад харьяалагддаггүй, цалин урамшуулал олгодоггүй нь үүрэг хариуцлага тооцох боломжгүй;
- Хамтарсан багийн гишүүд орон тооны бус учраас дуудлага мэдээлэлд сум, багийн түвшинд эмч, цагдаа дуудлагад явсан зэргээс шалтгаалан шуурхай хуралд оролцдоггүй;

3.3.16 Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 7 дугаар зүйлийн 7.1, 7.2-т хүүхдийг аюултай нөхцөл байдалд орсон гэж үзвэл түр хамгаалах байранд байрлуулна гэж заажээ. Аймгийн хэмжээнд 4 сум түр хамгаалан байрлуулах байр, өрөөтэй, бусад 14 сум 2 тосгонд байхгүй байна.

3.3.17 Аймгийн төвийн түр хамгаалах байрны үйл ажиллагааг магадлан итгэмжлэгдээгүй төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж байна.

3.3.18 “Хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлага MNS 6040:2019 стандарт”-ын хүүхэд хамгааллын асуудалтай холбоотой 17 үзүүлэлтээр хяналт хэрэгжүүлэхэд түр хамгаалах байранд гаднын хүн нэвтрэхэд урьдчилан зөвшөөрөл авдаггүй, ажилтнууд нууцын баталгааг гаргаагүй, үйлчилгээ үзүүлэх сургалтад хамрагдаагүй, мэргэшсэн хүний нөөцгүй, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн орчин, үйлчилгээгүй зэрэг зөрчил байна.

Дүрслэл 4. Түр хамгаалах байраар үйлчлүүлсэн иргэдийн тоо



Түр хамгаалах байраар 2019 онд 35, 2020 онд 56, 2021 онд 36, 2022 онд 26, 2023 онд 24 нийт 177 иргэн үйлчлүүлснээс 103 хүүхэд байна. Мэдээллээс харахад хүчирхийлэлд өртөж тус байраар үйлчлүүлсэн хүүхдийн тоо буурахгүй хэвээр байсаар байна.

Түр хамгаалах байр нь 2023 онд халамжийн сангаас 10.3 сая, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 20.0 сая, ХГБХХГ-аас 1.9 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг авч үйл ажиллагаа явуулсан байна.

Эх сурвалж: ХГБХХГ-ын 2019-2023 оны түр хамгаалах байрны үйл ажиллагааны тайлан

Зураг 2. Аймгийн Түр хамгаалах байр

Аймгийн Засаг даргын захирамжаар 2022 онд Түр хамгаалах байрны газрын асуудлыг шийдвэрлэж улмаар Японы элчин сайдын яамны “Өвсний үндэс-Хүний аюулгүй байдлын хангах тусламж”-ийн хөтөлбөрт барилгын ажлын төслийг хүргүүлж шийдвэрлүүлсэн нь орон нутгийн хүүхэд хамгааллын бодлогын асуудлыг шийдвэрлэсэн томоохон бүтээн байгуулалтын ажил болсон байна. Барилгын ажлыг 637.8 сая төгрөгөөр гүйцэтгүүлж, барилгын ажлын явц 2024 оны 9 дүгээр сарын байдлаар 70.0 хувьтай байна.



3.3.19 Аймгийн ГХУСАЗСЗ, Цагдаагийн газартай хамтран гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор сургалт, сурталчилгаа хийх ажлуудыг тухайн оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг ханган ажиллажээ.

3.3.20 Аймгийн хэмжээнд 2023 онд хүүхэдтэй холбоотой бүртгэгдсэн нийт гэмт хэргийн тоо өмнөх оноос 8-аар өссөн, гэмт хэргийн улмаас хохирсон хүүхдийн тоо 8-аар буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 10. Хүүхдийн үйлдсэн гэмт хэргийн судалгаа

Гэмт хэргийн төрөл	Хэргийн тоо					Нийт
	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он	
Хүнийг алах гэмт хэрэг	-	-	1	-	1	2
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	1	-	4	3	2	10
Хүчиндэх гэмт хэрэг	-	-	1	-	-	1
Хулгайлах	13	14	3	6	11	47
Дээрэмдэх	-	-	-	1	-	1
Залилах	3	1	-	2	-	6
Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах	-	-	-	-	-	-
Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах	-	-	-	-	-	-
Бусад гэмт хэрэг	-	-	-	-	6	6
Хүүхдийн үйлдсэн гэмт хэргийн тоо	17	15	9	12	20	73
Аймгийн хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн тоо	235	151	231	231	273	1121

Хүснэгт 11. Гэмт хэргийн улмаас хохирсон хүүхдийн судалгаа

Гэмт хэргийн улмаас хохирсон төрөл	Хэргийн тоо					Нийт
	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он	
Нас барсан	5	4	3	-	1	13
Гэмтсэн	14	1	12	6	6	39
Бусад гэмт хэрэг	10	7	12	15	6	50
Хохирсон хүүхдийн тоо	29	12	27	21	13	102
Аймгийн хэмжээнд нийт хохирогч иргэдийн тоо	228	165	238	247	270	1148

Эх сурвалж: Цагдаагийн газрын судалгаа

3.3.21 Хүүхдийн үйлдсэн гэмт хэргийн төрлөөр авч үзвэл хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 2023 оныг 2019 онтой харьцуулахад 0.5 дахин өссөн, хулгайлах гэмт хэрэг 1.2 дахин буурсан, хүнийг алах гэмт хэрэг 2021, 2023 онуудад

тус бүр 1, хүчиндэх гэмт хэрэг 2021 онд 1 үйлдэгдсэн бол олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэгт хүүхэд холбогдоогүй байна. Судалгаанаас харахад аймгийн хэмжээнд нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 6.5 хувийг насанд хүрээгүй иргэд үйлдэн, хохирогч иргэдийн 8.9 хувийг хүүхэд эзэлж байна.

- 3.3.22 Хүүхдийн үйлдсэн гэмт хэргийн төрлөөр 2019 оныг 2023 онтой харьцуулахад авч үзвэл хулгайлах, залилах, дээрэмдэх гэмт хэрэг буурсан, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, хүчиндэх, хүнийг алах, гэмт хэрэг өссөн байгаа нь анхаарал татахаар байна. Иймд урьдчилан сэргийлэх, нөлөөллийн арга хэмжээг тогтмол хийх шаардлага байгааг харуулж байна.
- 3.3.23 Судалгаанаас харахад аймгийн хэмжээнд нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 6.5 хувийг насанд хүрээгүй иргэд үйлдэн, хохирогч иргэдийн 8.9 хувийг хүүхэд эзэлж байна.
- 3.3.24 Хүүхдийн гэмт хэргийн дийлэнхийг хулгайлах төрлийн гэмт хэрэг эзэлж байгааг мэргэжлийн байгууллагатай хийсэн уулзалтаар хүүхдийн цахим орчин дахь хязгаарлалт байхгүйгээс энэ төрлийн гэмт хэргийн тоо нэмэгдсэн гэж тайлбарласан.
- 3.3.25 Аймгийн Цагдаагийн байгууллагаас насанд хүрээгүй хүүхдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хүүхэд, эцэг, эх асран хамгаалагчид өргөн хүрээг хамарсан сургалт, нөлөөллийн ажлуудыг зохион байгуулжээ.
- 3.3.26 Хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй төрийн байгууллагуудаас Цагдаагийн газраас бусад байгууллага ХГБХХГ-тай тоон мэдээллээ солилцдоггүй, салбарын тоо мэдээллүүдийг авч нэгтгэхэд зөрүүтэй, салбар хоорондын уялдаа, хамтын ажиллагаа хангалтгүйгээс бодлогын хэмжээнд нэгдсэн тоо мэдээлэлд дүн шинжилгээ хийх, хүүхдийг эрсдэлт нөхцөлд орохоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах боломж бүрдээгүй байна.
- 3.3.27 Боловсролын салбарт гардаг хүүхдийн хүчирхийллийн судалгаанаас харахад сургуульд суралцаж байгаа хүүхдийн 3.0 орчим хувь нь ямар нэгэн байдлаар хүчирхийлэлд өртөж, хүчирхийллийн тоо 2019 оноос өссөн үзүүлэлттэй байгаа нь салбарын хэмжээнд хүчирхийллийн эсрэг авах хариу арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах шаардлагатай байгаа юм.
- 3.3.28 Эрүүл мэндийн байгууллагын судалгаагаар осол, гэмтлийн улмаас нас барсан хүүхдийн тоо 2019-2023 онуудад өссөн, дунджаар нийт нас баралтын 30.0 хувь нь зам тээврийн ослоор амь үрэгдсэн, амиа хорлосон хүүхдийн тоо байсаар байна. Мөн осол гэмтлийн улмаас гэмтсэн хүүхдийн тоо өндөр нь аймгийн хэмжээнд хүүхэд хамгааллын асуудал хангалттай хэрэгжихгүй байна.

Дүрслэл 5. Үр хөндөлтийн судалгаа



Эх сурвалж: Аймгийн Эрүүл мэндийн газрын судалгаа

3.3.29 Судалгаагаар өсвөр насны охидын дунд үр хөндөлт тохиолдож байгаа нь бэлгийн боловсрол дутмаг, энэ насныханд зориулсан үйлчилгээ хүртээмжгүй, бэлгийн хүчирхийлэл далд хэлбэрт байгаа зэрэг олон шалтгаантай төдийгүй өсвөр насны охидын үр хөндөлт нь тэдний эрүүл мэнд, ирээдүйн амьдралын чанарт сөрөг нөлөөтэй юм.

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Аймгийн хөгжлийн дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүдэд хүүхэд хамгаалах талаар хэрэгжүүлэх арга хэмжээг тусгасан ч орон нутгийн төсвөөс хөрөнгө зарцуулахаар батлаагүй байна.
2. Хүүхэд хамгааллын чиглэлээр мэргэшсэн албан хаагчид дутагдалтай, статистик мэдээгээр эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн тоо абле цахим систем дэх хүүхдийн тооноос зөрүүтэй, нэгдсэн мэдээллийн сан бүрдээгүй байна.
3. Хүүхэд хамгааллын зардлын төсвийг бодит хүүхдийн тоон мэдээлэлд үндэслэн төлөвлөөгүй байна.
4. Шуурхай тусламж, хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний санхүүжилтийг зардлын аргачлал, нормативыг үндэслэн олгохгүй байна.
5. Хүүхэд хамгааллын талаар хэрэгжиж буй үйл ажиллагаанд тавих хяналт хангалтгүй байна.
6. Хүүхэд хамгааллын оролцогч талуудын хэрэгжүүлж буй арга хэмжээгээр нийгэмд эерэг нөлөөлөл бий болж байгаа хэдий ч гэр бүлийн орчин дахь зөрчил буурахгүй байна.
7. Хамтарсан багийн гишүүдийн ажлын чиг үүргийн хэрэгжилт хангалтгүйгээс эрсдэлт нөхцөлд орсон хүүхдэд үзүүлэх хариу арга хэмжээг бүрэн үзүүлдэггүй, салбар хоорондын уялдаа холбоо хангалтгүй байна.

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ: ЭРСДЭЛТ НӨХЦӨЛД БАЙГАА ХҮҮХДИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САНГ БҮРДҮҮЛЭЭГҮЙ, ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙГЭЭС ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН БОДЛОГЫГ ОНОВЧТОЙ ТОДОРХОЙЛОХ, ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭГ БҮРЭН ҮЗҮҮЛЭХ НӨХЦӨЛ БҮРДЭХГҮЙ БАЙНА.

Дүгнэлтэд үндэслээд нэгтгэсэн тайланд тусгуулах 3 санал, аймгийн Засаг даргад 3 зөвлөмж, Хүүхдийн эрхийн хууль зүйн хороонд 1 зөвлөмж, ХГБХХГ-т 41.5 сая төгрөгийн 5 заалт бүхий албан шаардлага, 4 заалт зөвлөмж, Боловсрол шинжлэх ухааны газарт 2 зөвлөмж, Мэргэжлийн боловсролын сургуульд 1 зөвлөмжийг тус тус хүргүүллээ.

НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ТУСГУУЛАХ САНАЛ:

1. Хүүхэд хамгааллын чиглэлээр ашиглаж буй системийн хөгжүүлэлт, ашиглалтыг сайжруулах
2. Хүүхэд хамгааллын тогтолцооны оролцогч талуудыг үнэлж, дүгнэх хууль эрх зүйн зохицуулалтыг хууль тогтоомжид тусгуулах асуудлыг судалж шийдвэрлүүлэх.
3. Хүүхдийн тусламжийн 108 утасны дуудлага мэдээлэл хүлээн авах цахим системийн үйл ажиллагааг зохицуулах заавар, журам баталж мөрдүүлэх талаар холбогдох байгууллагад уламжлах

ЗӨВЛӨМЖ:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАД

1. Хүүхэд хамгааллын чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээнд орон нутгийн төсвөөс зарцуулах эх үүсвэрийг батлуулж байх
2. Аймгийн хэмжээнд хүүхдийн эрх, хөгжил, хамгаалалтай холбоотой хөтөлбөрийг батлахдаа эрсдэлт нөхцөл байгаа хүүхдэд чиглэсэн арга хэмжээг тусган хэрэгжүүлэх
3. Хүүхдийн төлөө зөвлөлийн ажлын тайланг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлж, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах.

ХҮҮХДИЙН ЭРХИЙН ХУУЛЬ ЗҮЙН ХОРООНД

1. Үйл ажиллагааны тайланг Хүүхдийн төлөө зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлж байх

ХҮҮХЭД, ГЭР БҮЛИЙН ХӨГЖИЛ, ХАМГААЛЛЫН ГАЗАРТ

1. Абле цахим системд эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн мэдээллийг бүрэн оруулах
2. Хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний хэрэгцээг зөв оновчтой тодорхойлж, аргачлал нормативыг баримтлан төсвийг зарцуулах.
3. Хамтарсан багийн гишүүдээр нууцын баталгаа гаргуулж, нууцлалыг хангаж ажиллах
4. Хамтарсан багийн хүүхэд хамгааллын үйлчилгээг холбогдох хууль журмын дагуу үзүүлэхэд мэргэжил арга зүйгээр хангаж, хяналт тавьж ажиллах

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ГАЗАРТ

1. Боловсролын салбарын байгууллагуудыг бүрэн камертай болгох санхүүгийн асуудлыг шийдвэрлэх
2. Ерөнхий боловсролын сургуулиудын дотуур байрны аюулгүй байдал, орчин нөхцөлийг стандартад нийцүүлэх талаар арга хэмжээ авч ажиллах

МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД

1. Дотуур байрны аюулгүй байдал, эрүүл ахуй, орчин нөхцөлийг стандартад нийцүүлэх талаар арга хэмжээ авч ажиллах

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ТӨРИЙН АУДИТ

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:



**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ХҮҮХЭД, ГЭР БҮЛИЙН ХӨГЖИЛ,
ХАМГААЛЛЫН ГАЗАР**

Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, Жинст баг, 82093

Хөгжил 1400-14, Утас/Факс: 70-48-33-71

Цахим шуудан: gobialtai@fcy.gov.mn

Цахим хуудас: gobi-altai.fcy.gov.mn

2024.10.18

№

248

танай

-ны №

-г

**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүнд хийгдсэн гүйцэтгэлийн аудитын асуудлын бүртгэлтэй танилцаж илэрсэн зөрчлийг хүлээн зөвшөөрч байна. Асуудлын бүртгэлтэй холбоотой санал байхгүй болно.

Зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийг хангах төлөвлөгөө гарган ажиллана.

ДАРГА



Б.АЛТАЙБААТАР

20240348



**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ХҮҮХЭД, ГЭР БҮЛИЙН ХӨГЖИЛ,
ХАМГААЛЛЫН ГАЗАР**

Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, Жинст баг, 82093

Хөгжил 1400-14, Утас/Факс: 70-48-33-71

Цахим шуудан: gobi-altai@fcy.gov.mn

Цахим хуудас: gobi-altai.fcy.gov.mn

2024. 10. 25 № 255

танай _____ -ны № _____ -т

**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж
буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүнд хийгдсэн
гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжилтийг
хангаж ажиллана.

ДАРГА  Б.АЛТАЙБААТАР



20240929

ТЭМДЭГЛЭЛ



Ерөнхий боловсролын сургуулийн камержуулалтын судалгаа

Хавсралт2

№	Байгууллага	Тоо	Камертай	Камергүй	нэр	Нийт камерийн тоо	Үүнээс: ажиллахгүй	Камерын бичлэг	
								30 хоногоос дээш	30 хоногоос доош
1	Сургуулийн тоо	29	24	5	Тахын тал, Олон булаг, Алтан соёмбо бага сургууль, эрдэнэ, АШУУИС-ийн Говь-Алтай АУС-ийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургууль	678	87	16	8
2	Цэцэрлэгийн тоо	31	31	0		303	43	298	5
									Бигэр, Төгрөг, Жаргалан, Цээл, чандмань

